

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-36

1. "Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийн төсөл /Засгийн газар 2025.01.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/ 3-36

**Монгол Улсын Их Хурлын
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 12 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Дэлгэрсайхан, Х.Жангабыл, Н.Наранбаатар, Х.Тэмүүжин, Г.Хосбаяр, Д.Цогтбаатар, Ж.Энхбаяр, С.Эрдэнэболд;
Чөлөөтэй: Э.Бат-Амгалан, Н.Номтойбаяр;
Эмнэлгийн чөлөөтэй: Л.Энхнасан.

Нэг. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.01.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, шинжээч Г.Дөлгөөн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Ч.Анар, Б.Батбаатар, Б.Энхбаяр, Д.Ганбат, Б.Жаргалан, Г.Тэмүүлэн нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс

баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ө.Шижир, Н.Батсүмбэрэл, Д.Энхтүвшин, Ч.Анар, Б.Батбаатар, Э.Болормаа, Б.Энхбаяр, Д.Ганбат, П.Сайнзориг, Г.Тэмүүлэн нар үг хэлэв.

Г.Тэмүүлэн: “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгохыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Уг асуудлыг 16 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 10 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
14 цаг 12 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Тэмүүлэн: Өнөөдөр 1 дүгээр сарын 27-ны өдөр, 13 гишүүн хүрэлцэн ирснээр Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн хүрэлцэн ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар гишүүн, Чинбаатарын Анар гишүүн, Батын Батбаатар гишүүн, Нацагдоржийн Батсүмбэрэл гишүүн, Энхбатын Болормаа гишүүн, Батбаярын Жаргалан гишүүн, Пүрэвсүрэнгийн Наранбаяр гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Баттөмөрийн Энхбаяр гишүүн, Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн, гээд дутуу юм байхгүй байх, Дашдондогийн Ганбат гишүүн гээд хүрэлцэн ирсэн. Эдгээр гишүүд хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны ирц бүрдсэн байна.

2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал нэг асуудал байгаа. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгой нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ЗГ болон БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөл. Засгийн газар 1 дүгээр сарын 22-ны өдөр ирүүлсэн зөвшилцөх асуудал байгаад байгаа.

Өнөөдрийн Байнгын хорооны хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүд байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, Нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ЗГ болон БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг хэлэлцэж эхэлье. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг та бүхэнд танилцуулчихъя. Байнгын хорооны гишүүдийг хуралдааны танхимд дуудаарай.

ЗГ-аас хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан сайд хүрэлцэн ирсэн байна. Мөн тус яамнаас тус яамны ТНБД Жавхланбаатар дарга хүрэлцэн ирсэн байна, тус яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Намчинсүрэн дарга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга Ганбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Хулан, Гадаад харилцааны яамнаас ГХЯ-ны ТНБД Мөнхтүшиг, Мөнхтүшиг дарга орж ирж байгаа байх. ГХЯ-ны Хилийн хэлтсийн дарга Баяржаргал, Гадаад яамны 2 дарга орж ирж байгаа юм байна, дуудаарай. Зам, тээврийн яамнаас ЗТЯ-ны ТНБД Батболд дарга хүрэлцэн ирсэн байна, ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын дарга Итгэлт, ЗТЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын шинжээч Дөлгөөн. Эрдэнэс Тавантолгой компаниас ЭТТ компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Мөнхжаргал, ЭТТ компанийн

Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын захирал Түвшинжаргал, ЭТТ компанийн Борлуулалт, маркетинг тээврийн газрын дарга Цэрэндондог, ЭТТ компанийн Хууль, эрх зүйн газрын дарга Уянга гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ЗГ-ын ажлын хэсэг хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны гишүүд хуралдааны танхимд орж ирэхийг хүсье. ГХЯ-наас ГХЯ-ны ТНБД Мөнхтүшиг дарга хүрэлцэн ирсэн байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ЗГ болон БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг ЗГ-ын гишүүн Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан сайд танилцуулна. Таныг микрофонд урьж байна, 5 номер.

Ц.Туваан: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолын 2-т энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ ЗГ хоорондын хэлэлцээр, ажлын хэсгүүд хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, ААН хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулах, шаардлагатай бол эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төсөл санаачлах чиглэлээр ажиллахыг Монгол Улсын ЗГ-т даалгасугай гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын ЗГ-ын 2024-өөс 28 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны 1 дүгээрт Гашуунсухайт-Ганцмод, Хангимандал, Шивээхүрэн, Сэхээ боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж тусгасан. Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Хангимандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн, Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс тээвэрлэх нүүрс экспортлох хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчид ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

3.3.1.1-д уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ, 3.3.2.2-т хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж уул уурхайн экспортыг жилд 100 сая тоннд хүргэнэ гэж тус тус заасан. Уг хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулснаар Монгол Улс БНХАУ-ын хоорондын худалдаа, эдийн засаг, бүс нутгийн хамтын ажиллагаа, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжиж, улмаар Шивээхүрэн, Сэхээ, Хангимандал, Бичигт, Зүүнхатавч боомтуудыг төмөр замаар холбох нөхцөл бүрдэх бөгөөд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 2030 оноос 80 сая тонноор нэмэгдэх стратегийн ач холбогдолтой юм.

Монгол Улсын Ерөнхий сайдын 4 удаагийн захирамжаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 1955 оны Монгол Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсэг БНХАУ-ын талтай давхардсан тоогоор 60 орчим удаа уулзалт хэлэлцээр хийсэн.

Монгол Улсын нүүрсний олборлолт экспортын хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилт эрчимжиж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш шударга хүртээх боломж бүрдэхийн зэрэгцээ дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд, Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээр байгуулснаар төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая тонн түүнээс дээш, Тавантолгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая тонн хүртэл өсгөж, нүүрс олборлолтын нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх. Монгол Хятад 2 улсын төрийн тэргүүн нарын 2014 онд баталсан Монгол Улс БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал хэрэгжих нөхцөл бүрдэж, Монгол Улс БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаа, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа эрчимжих, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, эдийн засгийн өсөлт жил бүр 0,8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч, нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган ам.доллар-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5 хувьд барих зэрэг эдийн засгийн болон стратегийн томоохон ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ЗГ болон БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг Байнгын хороотой зөвшилцөхөөр танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Туваан сайдад баярлалаа. Хэлэлцээрийн төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг манай Байнгын хороонд танилцуулах учиртай байгаад байгаа. Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл гишүүн танилцуулна. Таныг микрофонд урьж байна.

Н.Батсүмбэрэл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-аас 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ЗГ болон БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлсэн билээ. Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаанаараа дээрх хэлэлцээрийн төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ. Төсөл санаачлагчийн зүгээс энэхүү хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг байгуулснаар Монгол Улс БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, бүс нутгийн хамтын

ажиллагаа, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжиж, улмаар Шивээхүрэн, Сэхээ, Хангимандал, Бичигт, Зүүнхатавч боомтуудыг төмөр замаар холбох нөхцөл бүрдэх бөгөөд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 2030 оноос нэмэгдэх боломжийг бүрдүүлнэ гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар зээлийн хэлэлцээрийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Батнайрамдал, Сайнзориг, Энхтүвшин, Жаргалан, Батсүмбэрэл нар асуулт асууж, хариулт авсан байна. Улсын Их Хурлын гишүүн Бямбасүрэн, Ганхуяг, Лувсанжамц, Батнайрамдал, Сайнзориг, Энхтүвшин, Батчимэг, Жаргалан, Батсүмбэрэл, Мөнхсоёл, Мандхай нарын гишүүд уг гэрээг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолд тусгагдсан заалтуудтай нийцүүлэх, Монгол Улс өөрөө уурхайн олборлолтын ажлыг хийх, хийх нь зүйтэй талаар, нүүрсийг үнэгүйдүүлэхгүй байхад анхаарах, хяналтыг сайжруулах, хувийн хэвшлийн гаргаж байгаа нүүрсийг уг төмөр замаар тээвэрлэх эсэх талаар, хэлэлцээрийн явцын талаар гаргасан мэдээллийг дэлгэрэнгүй гишүүдэд хүргэх, мөн мега төслүүдийн хяналтыг гэрээнд тусгах, бусад боомтуудын холболтыг хийх ажлыг эрчимжүүлэх, төсөл хэрхэн үр ашигтай ажиллах талаар, нийгмийн болон байгаль орчны асуудалд онцгой анхаарах, гэрээнд тусгагдсан сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн асуудлын талаар үг хэллээ.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын ЗГ болон БНХАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төслийг Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүнд баярлалаа. Зээлийн хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүдийн нэрсийг авъя. Гишүүд нэрсээ өгөөрэй. Санал тусдаа байгаа. Батбаатар гишүүн, Ганбат гишүүнээр тасалъя. Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Би түрүүн Эдийн засгийн байнгын хороон дээр асуултууд асуусан. Энэтэй холбогдуулаад өөр тодруулж асуух завсарлагаагаар хариу өгнө гэсэн өгч чадаагүй байгаа учраас тэрийг дахиж тодруулж асууя гэж бодож байна. Тэгээд энэ гэрээ харахаар бид Улсын Их Хурлын тогтоолоор хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын гэрээ байснаа энэ үргэлжлүүлээд юу хэлэлцээрийн нэр нь өргөжөөд нүүрс худалдах, тэгээд уурхайтай холбоотой гэрээ болчихсон энэ явж байгаа. Тэгээд энэтэй холбогдуулаад Хятадын талын компаниудыг Монгол талын гэрээ энэ оролцоогүй юм шиг иймэрхүү дүр зураг харагдаад байгаа юм. Тэгээд энэтэй холбоотой асуултууд байгаа.

Би тэгэхээр сүүлээс нь хэлье. Улсын Их Хурлын тогтоол дээр энэ сэргээгдэх Хятадын сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжих гээд тийм юм бол тогтоол дээр байхгүй байсан жишээлбэл ийм заалт ороод ирчихсэн байгаа. Энийг яагаад ороод ирсэн бэ гэдгийг надад түрүүн тайлбар хэлье гэсэн

хэлээгүй байгаа учраас дахиад асуучихъя. Дээр нь энэ Хятадын талыг дэмжиж байгаа юунууд гэхээр энэ уурхайн олборлолт дээр Монголчууд өөрсдөө чаддаг юмыг Хятадын талын ААН-үүдийн оролцоог дэмжинэ, таатай нөхцөл бүрдүүлнэ гээд хууль бус жишээлбэл тэр чинь тендер зарлаад явбал Хятадын компаниудад Монгол компаниудаас илүү нөхцөл олгоно гэж тийм юм байж болохгүй гэх мэтчилэн ингээд заалтууд орчихсон байна.

Дээр нь би түрүүн хэлсэн. Төмөр зам холбохын тулд эдийн засгийн өгөөжийг нь хангахын тулд нүүрсний гэрээ хийж байгаа гэж бодсон чинь нүүрсний гэрээ хийхгүй бол төмөр замын бүтээн байгуулалт чинь холбохгүй гэдэг ийм заалт жишээлбэл энэ дотор орчихсон явж байна. Тэгэхээр энэ асуудлууд Улсын Их Хурлын тогтоол дээр байхгүй байсан асуудлууд тэгээд зарчмын хувьд ингээд өөрчлөгдөөд ингээд ороод ирчихсэн байгааг гайхаад байна л даа. Тэгэхээр энэ зөвшилцөнө гэж орж ирэхээр бид нарын хувьд мэдээж зөвшилцөхгүй гэвэл буцаж нөгөө талтайгаа ярилцах юм уу энэ талаар ярилцах зайлшгүй шаардлагууд байгаа учраас энэ дээр тодруулга өгөөч.

Яагаад Улсын Их Хурлын тогтоол дээр байхгүй зүйлүүдийг нэмж оруулаад, байсан зүйлүүдийг нь хасаад, жишээлбэл тэр бусад боомттой холбоотой асуудлууд яах вэ тэрийг тайлбар өгчихсөн учраас дахиж дурдах хэрэггүй байх. Тэгээд энэ жишээлбэл хот байгуулалт гээд юм нэмчихсэн байна. Тэгээд нөгөө юутай холбоотой нүүрсний боловсруулалттай холбоотой заалтуудыг нь хасаад хаячихсан гэх мэтчилэнгээр гээд нэлээн юмнууд өөрчилчихсэн байна л даа. Тэгэхээр Улсын Их Хурал бол энэ олонхоороо Улсын Их Хурлын тогтоол баталчихсан учраас энэ хүрээндээ гэрээ хэлэлцээрээ хийхгүй бол яагаад ингэж нөгөө талынхаа эрх ашгийг харж, нөгөө талдаа хэтэрхий ингэж тал зассан ийм гэрээ болоод ороод ирэв? Тэр энэ саяын тэр заалтууд энэ Хятадын сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжинэ гэсэн энэ заалтууд дээрээ тайлбар өгөөч?

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Туваан сайд хариулах уу.

Ц.Туваан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энэ мэдээж бид бүхэн Монгол Улсын ЗГ тэгээд Монголчууд, мөн бид бүхэн ард иргэдээсээ сонгогдож гарч ирж байгаа ийм Их Хурлын гишүүд учраас Монгол Улсын, Монголчуудын эрх ашиг 1 дүгээрт тавигдана. Тэгэхээр тэр агуулгаас бүх энэ хэлэлцээр гэрээ ажлын хэсгийн үйл явдлуудад оролцсон гэдгээ хариуцлагатайгаар хэлье. Энэ өөрөө 2014 оны Монгол БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн хэлэлцээр хийснээс хойш энэ 3-ыг цогцоор буюу 11 жилийн хугацаанд энэ гуравласан байдлаар буюу тодорхой хэлбэл төмөр замын хил холболт, нүүрс худалдах, худалдан авах гэрээ, нүүрс уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх 3 бол ингээд цогцоороо нэг дор явна гэсэн ийм байр суурь нь, байр сууриар хэлэлцэгдэж яваа. Энэ бол өнгөрсөн 60 удаагийн ажлын хэсгийн бүх протоколууд дээр тусаад ингээд явсан зүйл гэдгийг хэлье.

Сэргээгдэх эрчим хүчин дээр бид бүхэн ЗГ, Ерөнхий сайд, ЗГ-ын гишүүд, Их Хурлын гишүүд, ер нь бид нарын зүгээс Монголчуудын амбиц гэж ойлгож болно. Нэлээдгүй зүйлийг энэ ЗГ хоорондын хэлэлцээр дээр Улсын Их Хурлын бүрэн эрх биш ээ, үндсэн чиг олгосон тогтоол хэлэлцэх үеэр 12 дугаар, 11 болоод сүүлд нь 12 дугаар заалт болж орсон энэ заалтуудад маш олон зүйлүүд орсон. Тэгээд энэ

олон зүйлүүд Их Хурлын өгсөн үндсэн чигийн дагуу ЗГ хоорондын хэлэлцээр болон түүнийг дагаж зурагдах 2 талын ажлын хэсгийн протоколуудад ороод явсан гэдгийг хэлье. Энэ дээр бид энэ хэлэлцээрийг байгуулахдаа мэдээж Улсын Их Хурлаас өгсөн үндсэн чигээс нэг ч зүйлээр нэмж, хасалгүйгээр ингээд баримтлаад явсан.

Шар шороон шуурга гэдэг зүйл энэ протокол болон хэлэлцээрт дурдагдаагүйгээр хасагдсан байгаа гэдгийг хэлье. Бусад нь ЗГ хоорондын хэлэлцээрт 2 улсын олон улсын гэж болохуйц гэрээнд орох зүйлүүдээ оруулаад мөн нарийн заалтуудыг протоколдоо оруулаад, оруулчихсан байгаа. Тэгээд энэ 2-ыг зэрэг зурна гэдгийг хэлье. Сэргээгдэх эрчим хүчин дээр Монгол Улс сэргээгдэх эрчим хүч буюу ялангуяа энэ нар, салхины маш давуу байдалтай геологийн энэ давуу байдлаа, байршлын давуу байдлаа ашиглаж эрчим хүч үйлдвэрлэж экспортод гаргаж орлого олох гэсэн ийм зүйлийг бид өмнөх үндсэн чиг дотор орсныг та бүхэн мэдэж байгаа. Энэ сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэхэд шаардлагатай тодорхой нарийн тоног төхөөрөмжүүдээс бид сая энэ завсарлагааны хугацаанд ярилцаж яалаа. Тоног төхөөрөмжүүдээс шаардлагатай зүйл байвал экспортоор авч болно гэдэг зүйл ангийг хэлье, зүйлийг нэмсэн. Энэ нь болохоор Монгол Улсад тэртээ тэргүй үйлдвэрлэж чадахгүй зүйлүүдийг бид аль нэг улсаас экспортоор авахаас өөр, импортоор авахаас өөр аргагүй гэдэг утга агуулагдана гэдгийг хэлье.

Мөн тэр хот байгуулалт, өөр юу байлаа, хот байгуулалт энэ тэрийг нэлээн томоохон асуудал учраас энэ хэлэлцээр дотроо оруулаад явахад болохгүй зүйлгүйгээр тусгаж өгсөн. Бусад нь орхигдоогүй гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Туваан сайд та дахиад л худлаа хэлээд байх юм. Энэ гэрээний чинь агуулгыг чинь харахаар Монголчуудын эрх ашгийг хамгаалсан өнцөг ерөөсөө харагдахгүй байна. Тэгээд Улсын Их Хурлын тогтоолын заалтууд орсон гээд байгаа. Би энэ тогтоол нь надад байна л даа. Энэ тогтоол дээр жишээлбэл би орхигдсон юмнуудыг нь тэгвэл хэлж өгье. Би буруу хардаг юм уу? 12 дугаар зүйл дээр нүүрсний гүн боловсруулах аж үйлдвэр гэдэг асуудал байсан байна. Говийг усжуулах гэсэн асуудал байсан байна. Шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх, хил холболт гэсэн асуудлууд байна. Орон нутгийн хөгжил гэсэн юм байна. Тэгээд дээр нь өөр энэ заалт чинь нэг хэдхэн юм үүрэгжүүлсэн юм байгаа юм. Шивээхүрэн, Сэхээ, Хангимандал, Бичигт, бусад Байтаг Улиастайн боомт эд нар гэсэн заалтуудыг яах вэ тусад нь гээд тайлбарлаад байгаа бол биш, тэгээд байхгүй мөртөө энд байхгүй юмнуудыг нэмчихсэн юм байхгүй юу. Энэ дээр хэзээ ч эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжих гээд бид тоног төхөөрөмж үйлдвэрлэдэггүй газар. Бид хэрвээ эрчим хүчний экспортоо дэмжинэ гэвэл болж байгаа байхгүй юу. Энэ чинь.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 5 номер Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Би хэлсэн. Энэ Үндсэн чиглэлийг барьж ажилласан гэдгийг дахиад хэлчихье. Дээрээс нь Монгол Улсын ЗГ-ын олон улсын хэлэлцээрийн драфтаа бид бичээд түрүүлж явуулсан. Энэ тэгэхээр бол нөгөө талын бичсэн юман дээр ажилласан юм шиг ийм зүйл байхгүй. Бид өөрсдөө драфтаа бичээд Их Хурлаас өгсөн үндсэн чиглэлийнх нь дагуу явуулсан. Мэдээж энэ яг үг, үгчлэн биш юу гэдэг юм тэр хэлэлцээр яг тэр чигээрээ ороод батлагдах биш, үндсэн чигээ авч

учраас нөгөө талаас энэ хэсгийг нь хэлэлцээртээ оруулъя, энэ хэсгийг нь протоколдоо тусгая гэдэг байдлаар оруулсан. Бид нарт протоколын бичиг баримтаа ер нь бараг 100 хувь тохирчхоод байгаа. Тэгэхээр энэ зүйл дотор шар шороон шуурганаас бусад зүйлүүд орсон гэдгийг хэлье. Сэргээгдэх эрчим хүчин дээр экспортлоход шаардлагатай тоног төхөөрөмж байвал бид импортоор авах боломжтой заалт гэж тайлбарлая.

Г.Тэмүүлэн: Туваан сайд ийм л зүйл сая асуугаад байх юм. Дахиад 2 дахиа ч сая асууж байна, дахиад тодруулж ч таарах байх. Оны өмнө 24 оны 12 сарын 27-ны өдөр буюу 58 дугаар тогтоол дээр яг 12 дугаар заалт дээр тусгагдсан асуудлууд, та бүхэнд өгсөн үндсэн чиглэлийн асуудлууд чинь өөр болчхоод байна гэдэг асуудлыг яриад байна шүү дээ. Тэгээд энэ дээр гол онцолж хэлээд байгаа саяын нэг жишээ болгож хэлж байгаа зүйл чинь 12 дээр нь сэргээгдэх эрчим хүчний экспортыг дэмжинэ гэсэн заалт байгаад байгаа юм. Сэргээгдэх эрчим хүчний экспортыг дэмжинэ. Тэр бол нөгөө талдаа Монгол Улсаас экспортлох эрчим хүчийг авна ч гэдэг юм уу ерөнхий гол агуулга нь эндээ байна гэсэн зүйлийг эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжинэ гэж оруулж ирж байгаа байхгүй юу. Тэгэхээр тоног төхөөрөмж гээд яагаад хаанаасаа нэмэгдчих вэ гэдэг асуудлыг онцолж л ерөнхийдөө асуугаад байна л гэж ойлгож байна. Тэгэхээр энэ дээр та тодорхой хариулт хэлээд, давхар би зүгээр экспорт чинь давхар явж байгаа биз дээ л гэдэг асуудлыг гишүүд сонирхож асуугаад байна гэж хараад байгаа шүү дээ. Тодруулчих уу та, 5 номер.

Ц.Туваан: Бид нарын хувьд энэ сэргээгдэх эрчим хүчний экспортыг ЗГ маш их чухалчилж байгаа. Энэ бол манайд боломжтой. Дээрээс нь бусад улсуудтай тодорхой хэлбэл бүгд найрамдах биш ээ, Арабын булангийн орнуудтай Монгол Улсын Ерөнхий сайд саяхан очиж айлчлал хийгээд тэд нартай тодорхой төслүүдийг хэрэгжүүлээд, энд энэ төсөл хэрэгжүүлээд экспортлох асуудал ярьж байгаа юм. Тэгэхэд энэ экспортлоход бид энэ төслөө хэрэгжүүлэхэд Монгол Улс өөрсдөө сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг үйлдвэрлэдэггүй учраас энэ төрлийн тоног төхөөрөмжийг экспорт экспортоор биш ээ, импортоор авч болно гэсэн агуулгаар орсон байна.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн нэмж тодруулъя.

Д.Энхтүвшин: Энэ дээр хариулт авч чадахгүй юм байна. Манайх тоног төхөөрөмж энэ дээр биш, өөр нэг тодруулах гээд байна гэхээр нүүрс хил холболтын төмөр зам чухал байгаа тэрийг бүгд ойлгож байгаа. Тэрийг дэмжиж байгаа. Тэрийг холбохын тулд эдийн засгийн өгөөжийг нь хангахын тулд нүүрсний борлуулалт уурхайтай холбоотой гэрээ хийнэ гэсэн болохоос биш, нүүрсний борлуулалтын гэрээ уурхай олборлолт, уурхай өгөхгүй бол төмөр замын гэрээ чинь хийхгүй гэдэг ийм урьдач нөхцөл болгочихсон ийм заалт ийм хэзээ ч Улсын Их Хурлын тогтоол дээр агуулгын хувьд ч гэсэн, үг үсгийн хувьд ч тийм юм байхгүй. Тэгэхээр яагаад ийм заалт орчихсон юм бэ?

Г.Тэмүүлэн: 5 номерт Туваан сайд хариулъя.

Ц.Туваан: Энэ дээр ерөөсөө Их Хурлаар батлуулсан 58-ын үндсэн чиг дотор энэ 3-ыг цогцоор гэдгээрээ байгаа. Энэ 3 гэрээг гурвууланг нь нэг дор цуг зурна гэсэн агуулга энэ дотор явж байгаа. Тэгээд танд үндсэн ажлын хэсгийн бүх протоколуудыг үзүүлж болно. Тэгээд 2014 оны иж бүрэн түншлэл болон тэрнээс

өмнө 3-ыг цогцоор гэдэг асуудал цуг орж ирсэн. Энэ салалгүй 11 жил явж байгаа ийм асуудал гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалтгүй байна л гэж үзээд байна. Энхтүвшин гишүүн дахиад тодруулъя даа.

Д.Энхтүвшин: Би үгийг нь яг өгүүлбэрээр нь уншиж өгье. ААН хооронд нүүрс худалдаж, худалдан авах урт хугацааны гэрээнд гарын үсэг зурах, Тавантолгой түлш уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагаа нь хил дамнасан төмөр зам бүтээн байгуулалтыг эхлүүлэх урьдач нөхцөл болно гэж байна. Тэгтэл Улсын Их Хурлын тогтоол дээр болохоор энэ дээр эдийн засгийн, энэ Тавантолгой төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдаж, худалдан авах урт хугацааны гэрээ гэсэн. Тэгэхээр ийм байрыг нь солиод сая та 3, гурвуулаа зэрэг хийх юм шиг явж байгаа боловч энэ оруулж ирж байгаа төслөөр чинь болохоор эхэлж нүүрс, уурхай хоёроо хийж байж энэ төмөр замыг чинь холбоно гэсэн ийм нөхцөлтэй ороод ирчихсэн би үг үсгээр нь хараад хэлээд байна л даа. Тэгэхээр та яг нэг юмаа л давтаад байна.

Г.Тэмүүлэн: 5 номер.

Ц.Туваан: Би харин дарааллыг нь би солиод байгаа юм болов уу даа. Ер нь яг энэ дотор байгаа 3-ыг цогцоор байгуулна гэдгийг нэг дор зурна гэж ойлгоно. Түүний 1 дүгээрт нь төмөр замын хил холболтын бүтээн байгуулалт, 2 дугаарт нь Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ, 3 дугаарт нь уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх энэ 3-ыг цогцоор нь 3-ыг цогцоор гэдэг ойлголтоор явж байгаа. Дахиад 3 асуудал байгаа. Тэр нь юу вэ гэхээр энэ явцад 1 дүгээрт нь Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах, 2 дугаарт нь ажлын хэсгийн протоколыг зурах, 3 дугаарх нь ААН-үүдийн хоорондын гэрээ гэсэн ийм л 2 гурвын тоотой холбоотой зүйл байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн асуулт асууя.

Ч.Анар: Яг адилхан асуулт байна. Энэ боомт холбоно, бид боомтоо холбоё, дэмжье гээд л энэ асуудлыг хэлэлцэж байгаа шүү дээ. Нүүрсний хэлэлцээр орж ирж байна. Яах вэ үндсэндээ боомтоо холбоод, нүүрсээ л экспортлоод л орлогоо нэмэх гээд байгаа юм. Тэгээд яг тэр чиг үүргээрээ ч гэсэн бид хэлэлцэхийг нь дэмжиж байгаа. Зөвшилцөл гэж нэг аягүй ойлгомжгүй ойлголт. Зөвшилцөөд, зөвшилцөөд тэр ажил нь саналууд нь орохгүй бол Их Хурал зөвшөөрөл өгсөн гээд явах гээд байдаг.

Тэгээд дахиад энэ төмөр зам боомтын асуудлыг хэлэлцэх гэж байсан чинь энэ гэрээ дээр ерөөсөө бараг бүх юмаа хийхээр тиймэрхүү зохицуулалтууд их орж ирсэн байна. Би нэг, олон жишээ байна л даа. Тэгэхдээ ганц жишээг нь ярья. Энэ 5.Бусад.Талууд хот байгуулалт, орон сууцжуулалт болон дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтарч ажиллана. Энэ урд талд нь хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллага Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац, түүний хамаарал бүхий хуулийн этгээдтэй, корпорац түүний хамаарал бүхий хуулийн этгээдтэй хамтран ажилладаг Хятадын санхүүжилттэй байгууллага, аж ахуйн нэгж. Тэгэхээр энэ санал нь цаанаасаа гарсан юм уу, манай талаас гарсан юм уу? Энэ нь өөрөө юу болох гэж байна вэ гэхээрээ яг бодитойгоороо бид нүүрсээ нийлүүлнэ. Тэр нүүрсний үнээр бид магадгүй шинэ

Зуунмод хот юм уу, Хархорин юм уу, тэр хотыг нүүрснийхээ төлбөрийн оронд хот барьж өгөх гэж байна. Магадгүй утаа шийдэж өгөх гэж байна.

Гэхдээ Монгол Улс чинь бие даасан тусгаар улс, өөрийн гэсэн бодлоготой, үзэл бодолтой, Сангийн яамтай, Эдийн засаг, хөгжлийн яамтай, төсөвтэй. Тэгэхээр энэ нь бол үүгээрээ юу үзэх гээд байна вэ гэхээрээ нүүрсний нийлүүлсэн төлбөрт эргээгээд бид нарын улсын нэгдсэн эдийн засаг болон санхүүгийн төлөвлөлтгүйгээр бүтээн байгуулалтын ажлууд Хятадын төрийн өмчит компани, хамаарал бүхий этгээдүүд хийгдэнэ гэсэн заалт шууд уншигдаж байгаа байхгүй юу. Тэгэхээр бид Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүд. Нүүрсний хэлэлцээр, боомтын хэлэлцээрийг бол дэмжиж байгаа зайлшгүй хэрэгтэй. Гэхдээ энэ яагаад ийм заалт байгаа вэ?

Г.Тэмүүлэн: Анар гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Анар гишүүний асуултад хариулъя. Тийм тавтай холбоотой асуудал тэгээд энэ дээр яах вэ ер нь энэ 2 улсын хэлэлцээр, Засгийн газар хоорондын хэлэлцээр энэ хэлэлцээрүүд ерөнхий байдаг. Уг нь энэ яриад байгаа процесс маань 2 улсын төрийн өмчит компаниудын хооронд гэрээ хийгдээд л явчхаж болох ийм эд байхгүй юу. Тэгээд энэ эргээд аль, аль талдаа хийгдэхгүй он удаан жил явсаар байгаад сүүлдээ түвшин нь ахисаар байгаад Улсын Их Хурлын түвшин, мөн Байнгын хорооны түвшинд ороод ирж байна. Зөвшилцөх гэдэг утга бол манай Монгол Улсын хуулиар байгаа ийм ойлголт. Энэ нь болохоор Засгийн газарт Улсын Их Хурлаас, тухайлбал Байнгын хороодоос Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг олгох гэж ингэж ойлгогдож явах юм байна лээ.

Энэ талууд хот байгуулалт, орон сууцжуулалт, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт гээд. Энэ дотор л сая Энхтүвшин гишүүн зарим нь хаашаа алга болчхов гээд хэлж байна. Зарим нь энд орчихсон байгаа. Тэгэхээр энэ дээр яах вэ Засгийн газар хоорондын хэлэлцээр учраас энэ томоохон хэсгүүдийг нь оруулаад, энэ дээр бид Их Хурлын чиглэлийн дагуу бүгдээрэнг нь оруулна гэсэн. Тэгээд Засгийн газар хоорондын хэлэлцээр дээрээ энэ томоохнуудыг нь оруулаад, бусдыг нь орхигдуулалгүйгээр мөн адилхан тэр миний уншсан танилцуулгын эхний өгүүлбэр дотор байгаа гарын үсэг зурагдах 2 дахь бичиг баримт буюу протоколдоо тусгаад явъя гэсэн ийм байдлаар орж байгаа. Энэ дээр би энэ ажлын хэсгийг ахалж байгаагийнхаа хувиар хариуцлагатайгаар хэлье. Энэ дээр эдгээр бүтээн байгуулалтад ямар нэгэн оффтейк болон бартер маягийн зүйл байхгүй.

Монголын талаас тэр 2-т нь байгаа нүүрс худалдах, худалдан авах гэрээ бол яг бэлэн мөнгөөр нүүрсээ худалдах ийм гэрээ байгаа. Энэ бүтээн байгуулалтуудыг хийхдээ ямар нэгэн байдлаар нүүрсээр оффтейк хийхгүй. Дээрээс нь энэ бол бид нарын Монгол талын амбиц. Өмнөх тэр 50, 58.11 дүгээр заалт болоод сүүлд нь 1 заалт нэмээд 12 болсон зүйл дотроо бид нэлээн их зүйлүүдийг ирээдүйд хийх 14 мега төсөлтэйгөө холбоотой бусад Засгийн газар, Их Хурал, Байнгын хороодын амбиц, мөн Их Хурал дээр гарсан зүйлүүдийг тусгаад, бөөнд нь оруулсан. Тэгээд тэр нь 2 салаад хэлэлцээр болон протокол хоёртоо туссан байгаа гэдгийг хэлье. Дахиад хэлье энэ дээр ямар нэгэн оффтейк гэрээ хэлэлцээний тухай ойлголт байхгүй.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн нэмж тодруулъя.

Ч.Анар: Туваан сайд та өөрөө хэлж байна л даа. Монгол талаас Их Хурал чинь энэ хэлэлцээрийг хийхдээ нүүрс боомтын хэлэлцээр хийх эрхийг л ЗГ-т өгсөн. Хот байгуулалт, цаашлаад хамтын ажиллагаа хийхээр бол тэр эрхийг өгөөгүй шүү дээ. Тэгээд энэ эрх авсан гэрээгээ орж ирэхдээ яагаад манай талын хүсэлт гэж нэрээр өөр эдийн засгийн болон техник, эдийн засгийн 2 улсын хоорондын хамтын ажиллагааны заалтууд орж ирээд байгаа юм бэ гэдэг, ямар учраас, та тэрийг нь хариулахгүй процессыг нь яриад байх юм. Яагаад ингэж ороод ирж байгаа юм бэ? Энэ чинь боомт холбох, нүүрс зарах, импортоо, экспортоо дэмжих л хэлэлцээр хийх зөвшөөрлийг Их Хурлаас ЗГ-т олж ирж байгаа юм. Гэтэл энэ заалтуудыг нь ингээд уншихаар бид өөрснөө оруулж өгсөн гээд байгаа юм. Энэ чинь тэгээд нөгөө хот байгуулах, орон сууцжуулалт, дэд бүтэц гээд. Энэ яг хуулийн хулгай шиг л.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Би процесс ярьсан байх. Зүгээр энэ дээр Монгол Улсын Ерөнхий сайд, ЗГ-ын давхар Улсын Их Хурлын гишүүн хийж байгаа гишүүд, дээрээс нь та бүхэн үндсэн чиг батлах үеэр Их Хурлын гишүүдийн, Байнгын хороодын гишүүдийн саналаар нэмж тусгагдаж байсан. Бүр тодорхой хэлэх юм бүүр төмөр замтай холбоотой юман дээр гэхэд л 11 дүгээр заалт дээр Ховдын Булганы Байтаг-Ярантын чиглэлээр авто замаар цэг тохирч гарц гаргах энэ тэр гээд асуудлуудыг оруулсан. Энэ бол Их Хурал өөрөө баталж өгч байгаа Улсын Их Хурлын тогтоол учраас Их Хурлын бүрэн эрх байгаа юм. Тэгээд бид батлагдсан үндсэн чигийнхээ хүрээнд л хэлэлцээр лүүгээ ороод явж байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Болсон уу Анар гишүүн? Батбаатар гишүүн асуулт асууя.

Б.Батбаатар: Энэ яах вэ Байнгын хороогоор орж ирээд зөвшилцлөө гэж бодъё. Гишүүд нь яаж кноп дарах юм байгаа юм. Зөвшилцлөө гэхэд ойролцоогоор хэдий хугацааны дараа гэрээнд гарын үсэг зурахад бэлэн болох ийм төсөөлөл байна уу? Яагаад асууж байна вэ гэхээр нөгөө Хятадын хаврын баяр ерөөсөө 2 хоногийн дараа эхлэх гэж байна шүү дээ цагаан сар нь. Тэгэхээр 10 хоног өнөөдрөөс цааш нь тоолбол 7 хоног юм уу, 10 хоног тэнд ажил явна гэхэд эргэлзэж байгаа юм. Тийм болохоор хэрвээ наана тэрнээс наана зурахааргүй бол бид Монголын цагаан сар болох болоогүй байж байна. Бид энэ удаа Байнгын хорооны хурлыг энэ асуудлыг хэлэлцэхээс жаахан хойшлуулж байгаад яримаар санагдаад байгаа юм.

Дээрээс нь нөгөө Хятадын Чайна энерги компанийн зүгээс Монгол талд гаргаж байсан баталгаа, амлалтууд энэ гэрээ, энэ боомтыг холбовол ийм, ийм зүйл дээр ингэнэ гэж байсан зүйлүүд. Тэд нар бол энэ гэрээнд ерөөсөө ихэнх нь алга болчихсон. Тэрийгээ компани хоорондын гэрээнд тусгана гэж байгаа юм уу, ямар нэг бичиг ирүүлнэ гэсэн тэр нь ирсэн юм уу, ирээгүй юм уу? Бид нарын Монгол талаас явуулсан гэрээний драфтыг Хятад талд очоод хэдэн хувь нь өөрчлөгдсөн юм бэ? Энэ хүмүүсийн гишүүдийн асуугаад байгаа нь тэр шүү дээ. Нөгөө талын сонирхлыг Хятадын ЗГ, Хятад талын компани тэгээд байгаа юм гэдэг байдлаар оруулж ирээд байна гээд хардаж байгаа гол өнцөг нь тэр. Бид нарын явуулсан энэ драфт бид нараас яваад бид нарынхыг хүлээж авсан юм гэвэл бид дотоод талдаа асуудал ярина.

Зайлшгүй нөхцөлүүд буюу энэ, энэ зүйлийг зөвшөөрөхгүй бол гэрээ хийгдэхгүй гэж байгаа юмнууд нь энэ юм гэдэг бас нэг ондоо асуудал. Тэр нөхцөлүүд нь Монгол талдаа болж байна уу, болохгүй юу гэж ярина. Бид өөрсдөө санал санаачилга гаргаад, саяын тэр Туваан сайдын хэлдгээр Монгол талын амбиц, манай талын амбиц гэж яриад байгаа юм тэр чинь яг үнэндээ Анарын асуугаад байгаа энэ бүтээн байгуулалтуудад нөгөө нүүрс нийлүүлэх Хятадын компаниуд энэ дотоодын бусад Тавантолгойгоос үл хамаарсан, яах вэ эдийн засгийн хувьд хамааралтай боловч алслалын хувьд жишээ нь Улаанбаатар хотын бүтээн байгуулалтууд, бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудад оронд нь та нар нүүрсээ өгчих энэ бүтээн байгуулалтыг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Асуултад хариульъя 5 номер.

Ц.Туваан: Батын Батбаатар гишүүний асуултад хариульъя. Энэ нэлээн он удаан жил удчихсан ийм төсөл. Тэгээд бид бүхэн нэлээн шуурхай ажиллаад, аль болох хурдавчлах, цаг алдахгүй байх асуудлыг нэлээн гол болгосон. Энэ дээр мэдээж Монгол Улсын талын алдсан алдагдсан боломж маш их боломж алдагдсан. Энэ гэрээ байгуулагдахгүй удах тусам бид нарт ирээдүйд алдах боломжийн асуудал байгаа юм. Тэгэхээр нэлээн яарч хийсэн.

Энэ хэлэлцээр зурагдсанаар өнөөдөр энэ зөвшилцөөд, Байнгын хорооноос Засгийн газарт Засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурах эрх буюу зөвшөөрлийг олгосноор Монголын талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Зам, тээврийн сайд, Хятадын талаас Хятадын Хөгжил шинэтгэлийн хорооны дарга зурснаар Засгийн газар хоорондын хэлэлцээр батлагдана. Энэ батлагдсан хэлэлцээр Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Их Хурлаар дахин хаврын чуулганы эхэнд ёсчлон батламжлагдаж байж яг бүрэн утгаараа хууль, эрх зүйн талаасаа бүх зүйл шийдэгдэнэ. Энэнээс цаашаа бол мэдээж компани хоорондын гэрээний асуудал ингээд явах юм. Тэгээд бид багцаа цаг гэж хэлсэн. Дээрээс нь маргаашаас эхлээд Хятадын хаврын баяр цагаан сар эхэлж байгаа, 2 сарын 4-нд ажил орох юм байна лээ. Тэгээд ирэх 2 сарын дундуур энэ гэрээг 2 талаасаа зурах ийм боломж бүрдэх ийм магадлалтай зүйлийг бид ярилцаж байгаа. Тэгэхээр энэ нэлээн өндөр түвшний уулзалтууд бол нэлээн нууцлалтай байдаг учраас би энийг микрофонд хэлэх боломжгүй байна.

Би аль болох хойшлуулалгүй энэ зөндөө удчихсан. Бид хэн байна, Туваан байна уу, хэн байна уу нэг нь байвал барьж аваад хийгээд ингээд л гүйж, юу батлуулахын төлөө явах байх. Хойшлуулах нь эргээд маш олон зүйл дээр ялангуяа энэ ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөр та бүхний баталж өгсөн 14 мега төслийн нэгдүгээрх энэ тэр гээд ингээд л их ач холбогдол өгч байгаа зүйл цаг хугацаа хойшлуулах болов уу гэж бодож байна. Тэгэхээр эрхэм Байнгын хорооны гишүүд ойлгож, дэмжиж өгөөсэй гэж ингэж хүсье.

Мэдээж түрүүний Их Хурлын баталж өгсөн үндсэн чиглэлийн асуудал үндсэндээ 2 хуваагдаад Засгийн газар хоорондын хэлэлцээр, дээрээс нь протокол 2-т туссан байгаа. Үүний ар дээр нарийн заалтууд компани хоорондоо хооронд хийгдэх тэр гэрээнүүд дээр нэлээн детальны тусаж өгнө гэдгийг хэлье. Их Хурлын үндсэн чиглэл баталж өгсний дараа Монголын тал бид Засгийн газар Засгийн газрын хоорондын хэлэлцээрийнхээ драфтыг Монголын тал өөрсдөө бичээд, үндсэн чиглэлдээ тааруулж өөрсдөө бичээд 100 хувь манай санал явсан. Таны ярьж байгаа бичиг гэдэг нь энэ саналын хариу Монголын тал руу Хятадын талаас

ийм, ийм зүйл дээр гээд үндсэндээ 3 зүйл дээр санал өгч орж ирсэн. Энэ 3 зүйлээс нь бид тодорхой зүйлүүдийг авах боломжгүй гэдэг ийм хариугаа ирүүлээд буцааж явуулсан. Дахиад Хятадын талаас энэ дээрээ зөвшилцөөд ийм байдлаар тохирвол болж байна уу гэдэг хариу. Өөрөөр хэлбэл энэ хоорондоо ингээд 2, 2 яваад одоо яг та бүхэн дээр ирчихсэн байгаа энэ албан хэрэгцээнд гээд ярьж байгаа энэ бичиг баримт бол 2 тал яг эцсийн байдлаар одоохондоо яг одоогоор эцэслэн тохиролцсон хувилбар гэж ингэж ойлгож болно.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн нэмж тодруулъя.

Б.Батбаатар: Энэ нөгөө зөвшилцөхгүй гээд буцаахаар үндсэндээ энэ гэрээ чинь хэсэг зогсож таарна. Тэгээд яаж тэрнээсээ гарах юм гэдэг тухай яриа үүснэ. Алдагдсан боломжийн өртөг гээд ярьж байгаа. Одоо алдагдах ирээдүйн үнэ цэний асуудлыг буцаагаад сөхөж тавьж байгаа нөгөө талд нь. Энэ өөрөө юу хэлж байна вэ гэхээр одоо та нар кнопоо дарж өг гэдэг албан шаардлага болоод хувирчхаж байгаа юм. Тэгэхээр миний бодлоор яах вэ тодруулж асууж байгаад дараа нь үг хэлж нэмээд яах вэ гээд горимын зөрүүтэй санал гаргаад зүгээр Байнгын хорооны 2 сарын 4 хүртэл чинь 7 хоногийн зай байна шүү дээ. Бидэнд ямар нэг давхцал байхгүй. Хятад талд мэдээж ажлын цаг байхгүй, баяр ёслол нь эхэлчхэж байгаа. Тийм болохоор энэ дээр нэг Засгийн газар Байнгын хорооны.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж Батбаатар гишүүний микрофоныг өгье.

Б.Батбаатар: Тийм болохоор ЗГ энэ дээр нэг Байнгын хорооны гишүүдэд тодорхой мэдээлэл дахиж өгч байж, шууд энэ гэрээг зөвшилцөх, ... авахын өмнөх дахиж нэг зүйл хийхгүй бол болохгүй юм байна гэж хараад байгаа юм. Энэ горимын саналыг Байнгын хорооны дарга хураалгаж өгөөч гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Санал хэллээ. Энхбаяр гишүүн асуулт асууя.

Б.Энхбаяр: Энэ хил дамнасан төмөр замыг барих гэхээсээ илүү нүүрс худалдах, худалдан авах ийм хэлэлцээр, ЗГ хоорондын хэлэлцээр орж ирж байна. Өнгөрсөн хугацаанд ЭТТ компани 9 удаагийн оффтейк гэрээ байгуулсан байдаг. Одоогоос яг нэг жилийн өмнө нүүрсний хулгайтай холбоотой Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо байгуулагдаж, энэ гэрээнүүдийн тэр дотроо нүүрс худалдах, худалдан авах үнийг яаж тогтоосон юм бэ гэдэг асуудлыг 1 сарын турш ярьж, улмаар энэ нүүрсний хулгайтай холбоотойгоор 2024 оны 1 сарын 16-ны 09 тоот Улсын Их Хурлын тогтоол гарсан. Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоол бол хууль тогтоомжийн нэг хэсэг бөгөөд ЗГ баримтлах ёстой. Энэ 9 тоот тогтоолын 3-д Эрдэнэс Тавантолгой, Тавантолгой ХК болон төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээдээс цаашид төсвийн шинжтэй компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хоригдох арга хэмжээ авах гэдэг заалт туссан.

Миний хувьд оны өмнө Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж энэхүү нүүрсний хулгайтай холбоотой гарсан Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг заалт нэг бүрээр асуулга авсан. Энэ тогтоолын хэрэгжилтийг 2025 оны 1 сарын 17 ХЭГ/156 тоот албан бичгээр 64 хуудастай ирсэн байгаа. Саяны миний уншсан заалт хэрэгжилт байхгүй байна. Мөн энэ Чайна Энержитэй холбоотой хэлэлцээрт нүүрс худалдах, худалдан авах гэрээтэй холбоотойгоор ЭТТ-н 5 бүлэг ордоос аль ордоос гэрээг энэ нүүрсийг зарах гэж байгаа юм бэ гэдэг асуудал байхгүй байна.

Тухайлбал энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар ЭТТ компани нүүрс баяжуулах үйлдвэр барих гэдэг халхавчаар ЭТТ-н Цанхын дараа орох 400 их наядын нүүрсний нөөцтэй Бортээгийн уурхайн нүүрс борлуулах, худалдан авах монопол эрхийг Админерал компанид давуу байдалтай олгосон энэ хууль тогтоомж зөрчсөн бөгөөд энийг хүчингүй болгохыг Засгийн газарт даалгаж шийдвэрлэсэн. 1 жилийн хугацаанд энэ Улсын Их Хурлын тогтоолыг хэрэгжүүлээгүй гэдгээ сая Засгийн газар энэ бичгээр ирүүлсэн байгаа.

Тэгэхээр би энэ асуудлыг нүүрсний хулгайтай асуудалтай Монгол Улсын Засгийн газар эвлэрч байгаа бөгөөд улс төрийн манлайллын хувьд нүүрсчдийн гарт бүрэн эзлэгдсэн байна гэж ойлгож байна. Нүүрсчидтэйгээ тэмцэх улс төрийн легитим байдал танай Засгийн газарт байгаа юм уу? Энэ хэлэлцээрийн заалтад орж ирж байгаа жишээлбэл 3 дахь заалтад 2 талын өмнө нь байгуулж байсан нүүрс худалдан авах урт хугацааны гэрээний жишгийг харгалзаж үнийг тогтоох гэж байгаа. Би энэ ЭТТ компани нүүрсээ үнээ яаж тогтоодог юм бэ гэдгийг өнгөрсөн онд нүүрсний сонсгол дээр асуугаад олж чадаагүй. Аргачлал байхгүй, Серикжан гэж дарга л тогтоодог юм байна лээ. Яаж тогтоодгоо хэлээгүй. Тэгэхээр тийм аргачлалаар энэ дахиад нүүрс худалдан авах гэрээгээ хийх гэж байгаа юм уу гэсэн.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүний асуултад хариулъя, 5 номер.

Ц.Туваан: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын ЗГ Улсын Их Хурлаас тодорхой ЗГ-ын үйл ажиллагаа, яамдын үйл ажиллагаа эрхлэх үүрэг чиглэлтэйгээр ингээд Их Хурлаас байгуулагддаг. Тэгэхээр Их Хурлын өмнө энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ийм үүрэгтэй ийм бүтэц. Энэ үүргийнхээ дагуу Их Хурал, хууль тогтоомж, Их Хурлын тогтоол шийдвэрийг биелүүлж ажиллах ийм үүрэгтэй. Тэгэхээр тэр үүргийнхээ хүрээнд ажиллана гэдгээ ажиллана, мөн ажиллаж байгаа гэдгээ хэлье.

Мэдээж энэ авлигатай холбоотой хууль бус асуудалтай би ЗГ-ыг бүрэн төлөөлөхгүй. Өөрийнхөө хувь ЗГ-ын гишүүн, Их Хурлын гишүүнийхээ хувиар ийм зүйлтэй эвлэрэхгүй гэдгээ албан ёсоор энд хэлье. Нүүрсний үнэтэй холбоотой Бортээгтэй холбоотой асуудлууд дээр манай ЭТТ компанийн удирдлага ирсэн байгаа. Нэмж хариулна. Нүүрсний үнэтэй холбоотой асуудал дээр яг таны уншсан өгүүлбэрээр Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолоор баталж өгсөн үндсэн чиглэл дотор яг тэр байдлаар тусгагдсан. Энэ хэлэлцээрт орж ирсэн заалтаараа яг энэ утгыг хангаж байгаа гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Тавантолгой компанийн гүйцэтгэх захирлын үүргийг орлон, үүрэг гүйцэтгэгч захирлын Мөнхжаргал захирал хариулах уу? 7 номер.

Х.Мөнхжаргал: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Үнийн хувьд үнэтэй холбоотой асуулт асуусан. Уг үнийн хувьд форвард гэрээний үнийг бид нээлттэй сонгон шалгаруулалт гэж байсан юу байхгүй. Тийм учраас нөгөө урт хугацаагаар тогтож байгаа энэ хэлцэл маань өөрөө урт хугацааны хэлцэл гэдэг агуулгаараа Хятадын талаас урт хугацаагаар хэрэгжиж байгаа гэрээний үнэ гэдэг саналыг тавьсан байгаа. Монголын талаас буюу компанийн зүгээс хил нөхцөлөөрөө биржийн үнэ, дундаж үнэ гэдэг саналыг тавьсан боловч буцаагаад ирсэн хариулт нь тийм байгаа.

Биржийн арилжааны форвард гэрээний доод үнийг Ганцмод боомт дээрх үнээр тогтоож байгаа. Нийтдээ 5 индекс ашиглаж тогтоож байгаа буюу нэтфак аргачлалыг бид ашиглаж тогтоож байгаа болно. Юун дээр ордын хувьд 2 орд байгаа. Бортолгой, Ончхараат гэсэн 2 орд дээр одоо бол энэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хэлэлцээрийн агуулга нь явж байгаа. Бортээгийн Админерал компанитай холбоотой Бортээгийн асуудал дээр компанийн зүгээс ажлын хэсэг гаргасан. Энэ ажлын хэсэг дээр хувьцаа эзэмшигч буюу Эрдэнэс Монгол нэгдлээс ажлын хэсэгт гишүүнээр ажиллаж байгаа. Тэгээд хамтын ажлын хэсэгтэй байгаа. Дэлгэрэнгүй мэдээллийг манай Хууль, эрх зүйн газрын дарга өгөх болно.

Г.Тэмүүлэн: 8 номер, албан тушаалаа танилцуулаарай.

Э.Уянга: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Хууль, эрх зүйн газрын дарга Уянга байна. Админерал компанитай холбоотойгоор Улсын Их Хурлын 24 оны 9 дүгээр тогтоолоор заасан үүргийн дагуу МТАС түншлэлтэй байгуулсан Бортээгийн уурхайд ажил гүйцэтгэх гэрээг хүчингүй болгох, цуцлах үүрэг өгчихсөн. Энэ гэрээний хувьд энэ гэрээ өөрөө хэрэгжиж эхлээгүй, хэрэгжих, гэрээ хэрэгжиж эхлэх нөхцөл нь Админерал компани хуурай аргаар нүүрс баяжуулах үйлдвэрээ ашиглалтад оруулсан тохиолдолд гэрээ хэрэгжиж эхлэх ийм нөхцөлтэйгөөр байгуулагдсан гэрээ байгаа.

Их Хурлын хянан шалгах түр хорооноос явагдсан сонсголтой холбоотой асуудлын хүрээнд Авлигатай тэмцэх газар энэ хэргийг шалгаж байгаа. Бидний зүгээс холбогдох материалуудыг гаргаж өгөөд, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах ажиллагаанд оролцоод ажиллаад явж байгаа. Эрдэнэс Монгол компани Эрдэнэс Тавантолгой компанийн толгой компанийн хувьд бид энэ МТАС-ын гэрээг цуцалсантай холбоотой хууль зүйн үр дагавар талаасаа ажлын хэсэг байгуулсан. Эрдэнэс Монгол талаас Мөнхжаргал гээд яг аж үйлдвэржилт талаасаа мэргэжилтэн оролцоод ажиллаж байгаа. Бид ажлын хэсгийн дүгнэлтээ өнгөрсөн 5 дахийн байдлаар нэгтгээд гаргачихсан, энэ долоо хоногтоо тус гэрээг цуцлах мэдэгдлийг албан ёсоор хүргүүлэхээр ингээд төслийн шатдаа ороод ажиллаж байна. Боллоо.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн нэмж тодруулъя.

Б.Энхбаяр: Нүүрсний сонсгол хийгдээд, сүүлийн нэг жил нүүрсний хулгай хийсэн гэх энэ компаниуд намайг шүүхдээд нэг жил болж байгаа юм. Өнгөрсөн долоо хоногт миний бие бүтэн жил шүүхдээд, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 12 сарын 27-ны өдрийн 210/МА, 2025/00033 тоот магадлал гарсан байгаа. Энэ магадлалаар сая яригдаж байгаа нүүрсний хулгай хийсэн гэх компанийг миний бие гүтгэсэн нь гүтгээгүй байна гэж шийдвэр гарсан. Тэгвэл тэр хүмүүс хулгай хийсэн гэдэг нь би шүүхээр эцэслээд тогтоогдсон гэж ойлгож байгаа юм.

Г.Тэмүүлэн: Энхбаяр гишүүн минут нэмж өгье.

Б.Энхбаяр: Тэгэхээр энэ чинь аль нэг тал нь гүтгэсэн бол аль нэг тал нь буруутах ёстой. Би гүтгээгүй гэдэг нь шүүхийн эцсийн шийдвэрээр нотлогдсон бол тэр хүмүүс нүүрсний хулгай хийсэн гэдэг нь шүүхээр би тогтоогдлоо гэж ойлгож байгаа. Тэгэхээр ЗГ өөрөө энэ асуудал дээр ер нь миний анзаарч байгаагаар нүүрсний хэрэг ярьж байгаа зүйл ерөөсөө харагдахгүй байгаа. Нүүрсээ заръя л

гээд байгаа. Би нүүрс зарахгүй гэж ерөөсөө байр суурь баримталдаггүй. Монгол Улс зарах ёстой, хөгжих ёстой. Тэгэхдээ нүүрсний нэгэнт тогтоогдчихсон хулгайчидтайгаа хариуцлага тооцохгүй, одоо хүртэл гар хөл нь болчихсон, тэд нараараа нүүрсний гэрээ байгуулахыг би дэмжихгүй байгаа. Би дахиад хулгай хийнэ гэдэгт итгэлтэй байгаа.

Г.Тэмүүлэн: Үг хэлчихлээ. Ганбат гишүүн асуулт асууя.

Д.Ганбат: Энэ Улсын Их Хурлын 58 дугаар тогтоол, өнөөдрийн та бүхнээс оруулж ирж байгаа энэ ЗГ-ын хэлэлцээр энэ бүх юм чинь Монголын ард түмний язгуур эрх ашигт нийцэж байна гэж үзэж байна уу? 1 дүгээр асуулт.

2-т нь яах вэ дээ нэг хэдэн жилийн өмнө цагдаагаас тэгдэг байсан л даа. Ятгах тусам сайн нягтал гэж. Тэр маш их зөв зүйтэй ийм уриа байсан л даа. Сүүлийн үед залилан луйвар Монгол даяараа хангалттай явж байна. Тэгэхээр бид нарыг ерөөсөө нягтлах тийм юмыг нь олохгүй байна л даа. Жишээлбэл энэ Улсын Их Хурлаас гарсан тогтоол байна. Энэ тогтоолын гарчиг нь төмөр замын хил хоорондын дамнасан төмөр зам болчхож. Энэ дотроо болохоор хил холболт гэхчхэн байгаа. Үгүй ээ хил дамнасан зам юм уу, хил холболт юм уу аль нь юм бэ? Би наана байсан мухар зам бол цаашаа Хятадын хил гараад л мухар зам хэвээрээ байна гэж бодож байгаа. Тийм ч юм билээ. Очиж харсан. Энэ тогтоол дээр 2 дахь, 2 заалт байгаа юм. 6-д нь өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахин үүсэхгүй. Үгүй ээ өргөн, нарийн царигаа бид ярих л ёстой л доо. Бид аль болохоор эдийн засгийн үр ашигтай тийм замыг сонгох л ёстой байхгүй юу.

Хэрвээ бид буруу замаар явж байгаа бол зогсоод, буцаад зөв замаар орох ёстой. Буруу замаар явсаар байгаад дуусгана гэсэн ийм юм байхгүй. Ийм энгийн юмнуудыг яагаад ингээд ойлгохгүй байна. Тэгээд 9-д нь бол бас заачихсан байна. Өнгөрсөн хугацаанд аливаа алдагдал, хохирол болон энэ юмыг нэхэмжлэхгүй гэсэн байгаа юм аль, аль тал нь. Энэ чинь тэр байтугай хэд нугалаад л бид нараас авна шүү дээ. Тийм юм цаад талд нь байна. Тэгээд 2014 онд Хятадын дарга Ши Жиньпин айлчлаад Улсын Их Хурал дээр орж ирээд хэлж байсан. Бид хурдны төмөр замдаа суучихсан явж байна, хурдны галт тэргэнд та бүхнийг урьж байна гэж байсан. Бид ингээд Гашуунсухайтаас Далянь, Тяньжинь хүрэх зам бол төмөр зам 1500 юм билээ. Хэрвээ бид зөв холбогдож чадаад ингэчих юм бол гуравдагч орны зах зээл.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж минут өгье.

Д.Ганбат: Гарчих юм байна лээ. Тэгээд ийм юм чинь эргээд байхгүй болж байна. Уул уурхайн яамнаас тэр Ганцмод-Гашуунсухайтын бүх юмтай танилцах боломж олгосон л доо. Би явж танилцсан. Хэдийгээр жоохон өвчтэй байсан боловч. Шанхай ч гэсэн Энхбаяр гишүүн бид 2 өөрөө зардлаа даагаад очиж байсан. Тэгээд үзэж харж байж юмаа ярья гэж бодоод байгаа байхгүй юу. Тэгээд нэг иймэрхүү байдалтай байна. Энийгээ та бүхэн юу гэж ойлгоод яах гээд байна вэ? Тийм. Манай хэдэн гишүүд бүгд очсон. Тэгээд энэ гишүүдийг 126 гишүүний давуу тал нь юмыг тал талаас нь ингээд сайн ярих, нягтлах ийм боломжийг нь өгөхгүй байна гэж хараад байгаа байхгүй юу. Яагаад ингээд байгаа юм бэ? Дараа нь асуухад энэ Засгийн газар, энэ Улсын Их Хурал энэ нүүрс, төмөр зам энэ бүх юмтай холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй хүмүүс байна уу? Та нар ингээд зэрэгцээд суучихсан энэ хүмүүс дотор ч гэсэн байгаа.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүний асуултад хариулъя, 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Хууль дээдлэх зарчмаар хуулийг биелүүлж, дагаж мөрдөх энэ зарчмаар ажиллаж байгаа гэдгээ хэлье. Энэ төмөр замын хил холболт дамнасан гээд бас энэ дээр Монголын талаас өргөн царигийн төмөр зам БНХАУ-ын нутаг руу ороод тэндээ терминал дээр ачаагаа буулгана. Хятадын талаас нарийн царигийн төмөр зам орж ирээд Монголын талд терминал дээр ачаагаа буулгана. Олон улс хоорондоо мөрддөг төмөр замын хэлэлцээрээр аливаа улс орон өөрийнхөө царигаар нөгөө импортолж байгаа тал руугаа орох юм бол нөгөө талынх нь эсрэг тал руугаа экспортлогч тал руугаа гэсэн үг төмөр замаа өөрийнхөө орны царигаар оруулна гэсэн ийм олон улсын конвенц төмөр замын хэлэлцээр байдаг юм байна лээ.

Гуравдагч орны зах зээл дээр энэ Гашуунсухайт-Ганцмодны хил холболт хийгдсэнээс хойш энэ Ганцмодны боомт дээрээс цаашаа энэ төмөр зам тасалдахгүй үргэлжлээд БНХАУ-ын нутгаар яваад Тяньжинь, Тяньжиний дээд талын нэг боомт 2 луу шууд холбогдох ийм төмөр зам байна лээ. Тэгээд энэ төмөр замаар бид далайд өөрийн орны уул уурхайн бүтээгдэхүүнээ хүргэж, тэндээс цааш нь далайн тээвэрт гаргах ийм боломжтой юм байна лээ гэдгийг хэлье.

Энэ Улсын Их Хурлаар үндсэн чиглэл, үндсэн чигээ батлуулах Улсын Их Хурлын тогтоолын үеэр бид энэ асуудлаа бүх асуудлаа задгай нээлттэй Их Хуралд дээрээ хэлэлцээд явсан. Тэгээд тэр үеэр бид ямар нэгэн нууц далд юм үлдээлгүйгээр гишүүдийн асуултад хариулаад, бүх мэдээллээ ил гаргаж тавьсан гэдгийг энэ ташрамд хэлье.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн нэмж тодруулъя.

Д.Ганбат: Тэгээд тодорхой асуулт тавихаар тодорхой хариулт өгөх хэрэгтэй байна л даа. Тэгээд энийг чинь л би яриад байгаа шүү дээ. Өмнөх гишүүд ч гэсэн яриад л байна. Энэ чинь Монголын ард түмэнд ганц заяагдсан ганц боломж нь байгаа байхгүй юу Тавантолгойн бүлэг орд чинь. Энийг бид үр дүнтэй, зөв ашиглаад ингэчихвэл энэ ядуурал, хамаг юмнаас ч бид гарч чадах ёстой. Тэгээд 20-оод жил энэ нөхцөл байдал бий болохгүй байсаар байгаад л өдий хүрчихсэн. Одоо буруу замаар будаа тээх гээд байна гэж би хэлэх гээд байна шүү дээ. Буцахдаа шороотой тээх гээд байна. Бодвол миний хэлж байгаа ярьж байгаа бүх юм ингээд энэ протоколд үлдэх байх л даа. Нөгөө талаас нь харж чадсан уу, тооцоо байсан уу? Олон улсын стандарт зам буюу тэр замыг энэ хуучин Зөвлөлт холбоот улс гэж байсан. Энэ улсууд бүгд солиод эхэлчихсэн байна. Бүгд нарийн буюу тэр замаараа холбогдчихсон байна. Гэтэл яагаад заавал үүгээр ингээд шахаад.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Хэн хариулах вэ? Гараа өргөөрэй, 2 номер.

Х.Итгэлт: Зам, тээврийн яамны Төмөр замын газрын дарга Итгэлт. Монгол улс Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын гишүүн орон. Хятад улс энэ байгууллагын гишүүн орон. Тэгэхээр түрүүн Туваан сайдын хэлсэн өөрөө экспортолж байгаа бүтээгдэхүүнээ өөрийнхөө царигаар төмөр замаа хүргэж өгнө. Импортлогч улс маань буцаад манайд өөрийнхөө царигаар бүтээгдэхүүнээ өгнө гэсэн ийм л зохицуулалттай. Энийг бид 2014 оноос хойш өргөн, нарийн цариг

ингэж явсаар байгаад хамгийн сүүлд 2020 онд олон улсын гэрээний дагуу буюу энэ элсэж орсон байгууллагынхаа баталсан ачаа тээврийн хэлэлцээрт заасан дүрмээрээ шийдье гэж ингэж тохирсон байгаа юм. Хариулт боллоо.

Г.Тэмүүлэн: Хариулт хангалтгүй гэж үзсэн учраас Ганбат гишүүн нэмж тодруулья.

Д.Ганбат: Үгүй ээ тэгээд хэнд юу яриад байгаа юм бэ? Ийм, ийм байх ёстой ч гэх шиг. Тийм олон улсын гэрээ бичиг баримт байхгүй шүү дээ. Тэгээд нэг ийм юмаар хэн ч биш юмнуудаар яриулаад ингээд хүмүүсийн толгой эргүүлээд мунхруулаад байгаа байхгүй юу. Үгүй ээ энэ чинь хэчнээн төгрөгөөр, хэчнээн үнэ өртгөөр тэр төмөр замын вагоныг худалдаж авах вэ, яах вэ, ийх вэ, цааш нь боломжууд байхгүй болох уу? Энэ өмнөх баахан хулгайнууд яаж дарагдаад алга болох вэ? Түүн дээр хариуцлага тооцохгүй бол сая манай Энхбаяр гишүүний хэлээд байдаг үргэлжлэх юм байна гэж бас л хэлээд байна шүү дээ. Тэгээд Тавантолгойнхоо талыг өгөх ийм л маягтай юм болчих гээд байгаа юм биш үү? Энийг чинь бид л ярихгүй энэ дээр өөр хэн ярих юм бэ? Та нар бүгд нөгөө талдаа гарчихсан. Монголын ард түмний эрх ашгийн төлөө яваад ч байгаа юм уу, үгүй ч юм уу ийм л байдалтай байна шүү дээ. Энийг чинь л асуугаад тодруулахаар.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Нэмж хариулт өгөх хүн байна уу? Туваан сайд 5 номер.

Ц.Туваан: Бид бүхэн түрүүн хэлсэн алдагдсан боломж гээд. Манай яамныхан тодорхой судалгаа хийж гаргаад зөвхөн нүүрсний экспортоос 18,5 тэрбум ам.долларын боломжоо бид экспортын орлого олох боломжоо алдсан байна гэж үзэж байгаа. Энэ төмөр зам сая Ганбат гишүүнтэй санал нэг байна. Энэ төмөр замыг яаралтай холбохгүй бол бусад боомтууд холбогдохгүй 1 дүгээрт. 2 дугаарт Монгол Улсын авто тээврээр экспортод гаргах нүүрсний хэмжээ хамгийн дээд цэгтээ тулчихсан байгаа. Тэгэхээр бид нэмэлт экспортын гарцыг нээхээс өөр арга байхгүй. Ингэж байж бид ДНБ 1 хүнд ноогдох ДНБ-ээ нэмэгдүүлнэ гэсэн ийм зорилтыг тавьсан. Энэ зорилтыг Улсын Их Хурал үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж өгсөн байгаа. Энэ боомтууд ашиглалтад орсноор бид 2 давхар авто болон төмөр замаар экспорт нэмэгдэнэ. Нийтдээ 2030 оноос одоогийн экспортыг даблдаж 160 сая тонн нүүрс экспортод гаргана гэсэн ийм тооцоололтой ажиллаж байгаа.

Г.Тэмүүлэн: Үг дээр яах уу? Жаргалан гишүүн асуулт асууя.

Б.Жаргалан: Сая Эдийн засгийн байнгын хороон дээр нэлээн ярилцсан. Саяын хэлснийхээ Байнгын хороон дээр ярьсныхаа дагуу дахиад нэг зүйлийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хурал дээр хэлэхийг хүсэж байна. Тэр нь юу вэ гэхээр бид оны өмнө тогтоол баталсан байгаа. Тэгээд энэ хэлэлцээрт тогтоолд байхгүй байгаад байгаа нэг зүйл ороод ирчихсэн байж байгаа юм. Энэ нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг зүйл ангийн хүрээнд Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд Хятадын аж ахуйн нэгжийг арилжааны зарчмаар оролцохыг дэмжиж, таатай нөхцөл бүрдүүлнэ гэдэг нэг ийм өгүүлбэр ороод ирчихсэн нь нөгөө тогтоолд байхгүй өгүүлбэр шүү. Тэгээд энэ өгүүлбэрийг энэ хасаж, хэлэлцээрийг байгуулах шаардлагатай гэж үзээд байгаа юм.

Тэгээд үүнтэй холбоотойгоор дахиад нэг асуух зүйл юу байгаа вэ гэхээр уул уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхийн тулд Ончхараа, Бортолгой гээд 2 аман дээр шинээр ам нээх гэж байгаа гэж ойлгоод байгаа юм. Тэгмэгц 2023 оны 12 дугаар сард болохоор энэ 2 аман дээр олборлогч шалгаруулах нэг тендер зарлачхаад, тэр тендерийнх нь үр дүн нь тодорхойгүй, одоо болтол нөгөө tender.mn сайт дээр тэр нөгөө тендерийнх нь баримт бичиг нь ил байж байгаа нэг ийм асуудал байгаад байгаа юм. Тэгээд энэ тендер, өмнө нь зарлагдсан 2 жилийн өмнө зарлагдсан байсан тендерийн ажил чинь ер нь юу болсон юм бэ? Яагаад би ингэж асуугаад байна вэ гэхээр Тавантолгойн цахилгаан станцын асуудал яригддаг тийм ээ. Тэгээд энэ цахилгаан станц хэзээ, яаж ашиглалтад орох юм бэ гэхээр тендерт орсон ААН-үүд нь гомдол чирэгдэл гаргаад байгаа учраас шүүх дээр явж байгаа учраас энэ асуудлыг урагшаа явуулах боломж байхгүй байна гээд Засгийн газар яриад сууж байдаг. Тэгэхээр яг үүнтэй ижил төстэй нөхцөл байдал үүсээд, магадгүй өөр шалтгаанаар энэ юм чинь гацах магадлал байна уу? Ямар нэгэн арга хэлбэрээр. Тэгэхээр энэ асуудлаар нэг хариулт авах гэсэн юм.

Тэгээд давхар болохоор энэ хэлэлцээр байгуулагдсаны ар дээр протокол хамт батлагдана гээд байгаа, араас нь гэрээнүүд орж ирнэ гээд байгаа. Тэгээд энэ хил холболт хийгдэж байгаа энэ нөхцөлд ийм тээврийн ямар нэгэн хэлэлцээрүүд хийгдэх үү? Ер нь сая нэг олон улсын тээврийн гэрээ хэлэлцээрүүд гээд яригдлаа. Тэгэхээр энэ тээвэртэй холбоотой ямар хэлэлцээрүүд хийгдэх вэ? Үүнд манай тал ямар зүйлүүдийг чухалчилж авч үзэж байна вэ? Манай талын эрх ашиг, ашиг сонирхол үүн дээр юу байх вэ гэдгийг асууя.

Г.Тэмүүлэн: Туваан сайд асуултад хариульъя, 5 номер.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад манай ЭТТ компани, мөн ЗТЯ нэмээд тодорхой хариулаарай. Энэ дээр бид бүхэн түрүүн хэлсэн. Энэ Улсын Их Хурлын үндсэн чигээ батлуулж авсан энэ үндсэн чигийнхээ дагуу ЗГ хоорондын хэлэлцээрээ Монголын тал 100 хувь өөрсдөө бичээд Хятадын талд явуулаад, тэгээд энэ драфт дээр бид 2 талаасаа ажилласан гэдгийг хэлье. Тээвэр дээр бид энэ Монголын талын амбиц бол эхлээд Гашуунсухайтаа гялс гэрээ хэлэлцээрийг нь байгуулаад эхлүүлээд, шууд залгуулаад 3 боомт, Шивээхүрэн, Сэхээ, Хангимандал, Бичигт, Зүүнхатавч гээд. Нийтдээ 4 боомтын Хятадын талаасаа 4 төмөр зам 4-лээ ирчихсэн. Монголын талаас ямар нэгэн байдлаар 3 боомт дээр тодорхой төмөр замууд нь оччихсон Бичигт, Зүүнхатавч дээр ингээд очоогүй явж байгаа. Тэгээд үүнийг шат дараатай хийхийн тулд бид 2 улс хоорондоо төмөр замын тээврийн хэлэлцээрүүд баталдаг. Энэ дээр Шивээхүрэн Сэхээгийн боомтоор боомтын төмөр замыг холбох хэлэлцээрийн драфт Хятадын талаас саяхан манай талд ирсэн. Бид тун удахгүй хариуг нь өгөхөөр ажиллаж байна. Түүний дараагаар Хангимандал гээд ингээд дэс дараалалтай холбогдоод явна гэдгийг хэлье. Мөнхжаргал захирал тендер.

Г.Тэмүүлэн: 7 номер нэмж хариульъя.

Х.Мөнхжаргал: Жаргалан гишүүний асуултад хариульъя. Тендертэй холбоотой өмнө нь 2023 оны сүүлд зарласан байгаа. Тус тендерийг нээгээгүй. Энэ тендер нь өөрөө яг энэ хил холболтын төмөр замын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой 3-ыг цогцоор түүний бүтээн байгуулалт, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх тендер байсан. Хэлэлцээрийн явцад тус тендерийн өгөгдөл, нөхцөл, техникийн шаардлага Хятад талаасаа ерөнхийдөө өөрчлөгдсөн. Тэгэхээр

энэ тендер өөрөө анхнаасаа оролцогч орж ирээгүй тендер. Гэхдээ хаагаагүй байгаа. Бид ямар ч байсан хуулийн хүрээнд энэ тендерийг хаах үйл ажиллагааг зохион байгуулна.

Юуны одоо яригдаж байгаа уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх юун дээр 3-ыг цогцоор гэдэг агуулга дээр Хятадын талаас тодорхой саналууд тавьсан. Хэдий тийм боловч Монголын тал өөрийнхөө саналыг тавьсан байгаа. Үүнд нээлттэй тендер сонгон шалгаруулах энэ ажлыг зохион байгуулна гэдэг саналыг одоогийн байдлаар тавьчихсан явж байгаа.

Г.Тэмүүлэн: 5 номер нэмж хариулъя.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад ЭТТ-н 450мвт-ын цахилгаан станцын асуудал байгаа. Энэ цахилгаан станцын, цахилгаан станцаас үйлдвэрлэсэн эрчим хүчээр бид бүхэн энэ Оюу толгой төслийг хангах эхний зорилготой. Яагаад вэ гэхээр Оюу толгой төсөл дээр өнөөдрийн байдлаар Монгол Улс 125-аас 130 сая ам.доллар-ын эрчим хүчийг БНХАУ-аас импортолж авч байгаа. Энэ асуудал шүүхийн шатан дээр 2 талын шүүхийн маргаантай ингээд явж байгаа. Тэгээд тун удахгүй шийдвэрлэгдвэл энэ асуудал гацаанаас гарна.

Г.Тэмүүлэн: ЗТЯ нэмж хариулах зүйл байгаа юу? 2 номер.

Х.Итгэлт: Гашуунсухайт-Ганцмод дээр хил холболтын төмөр зам орохоор миний түрүүний дурдсан олон улсын хамтын ажиллагааны байгууллагад ачаа тээвэрлэх дүрэмд заасны дагуу 2 төмөр замын байгууллага жил бүр тээвэрлэх ачааны хэмжээ, нэр төрлөөрөө тохиролцох гэрээнүүд хийгдээд явна. Яг тээвэрлэлт дээр энэ механизмаараа ачааныхаа хэмжээ, нэр төрлийг ингээд жил бүр тохиролцоод явдаг. Шивээхүрэн Сэхээ дээр бид хэд 2024 оны 3 дугаар сард ЗГ хоорондын хэлэлцээр байгуулах хүсэлтээ Хятадын талд өгчихсөн байгаа. Шивээхүрэн Сэхээ боомтын хил дамнасан төмөр замыг хамтран барих ийм ЗГ хоорондын хэлэлцээрийн төслөө Хятадын талд өгчихсөн. Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын төмөр замын гэрээ байгуулагдаад энэ асуудлыг үргэлжлүүлээд ярилцана. Хангийг бол хилийн боомт болон тэдгээрийн дэглэмийн тухай ЗГ хоорондын хэлэлцээрт нэмж тусгаад, ингээд дараа нь ЗГ хоорондын хэлэлцээрээ байгуулах ийм шат дараалалтай ажиллаж байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Би тодотгоод асуух хэд хэдэн зүйл байна. Энэ дээр сая гишүүд ерөнхийдөө хэлээд байгаа зүйл маань л ерөөсөө энэ төслийн үнэ цэнтэй холбоотой, үр өгөөжтэй холбоотой асуудлыг асуугаад байгаа. Үүнтэй холбогдуулаад ер нь зүгээр нэг зүйлийг асуух гээд байгаа нь энд ерөнхий ерөнхий хэлэлцээр Улсын Их Хурлаар оруулж ирж байгаа энэ хэлэлцээрийн төсөл үндсэндээ 2 ЗГ-ын хооронд байгуулах гэж байгаа ерөнхий хэлэлцээр. Ерөнхий суурь зарчмуудаа би бас орж ирж байна гэж харж байгаа. Энэ тодорхойгүй зүйл нь нүүрсний үнийн асуудал байгаад байгаа юм. Үнэ дээр ер нь яг бид цаашдаа аль болох л үнээ нэмэгдүүлэх боломжоо болж өгвөл уг нь нээлттэй байлгах ёстой байгаад байгаа юм. Нээлттэй байлгах ёстой. Тэгэхээр та бүхний энд бичсэнээр үндсэндээ анхны үнэ, анхны үнэ дээр нэмэх нь хамтарч сонгож авсан улирлын индексийн үнийн тохируулга гэдэг асуудал орж ирж байгаа. Тэгэхээр энэ үнийн аргачлал болоод харилцан зөвшилцсөн энэ механизм гэдэг зүйл маань нэг тодорхой байх ёстой. Энэ дээр яг ерөнхийдөө ямар байдлаар тохирч байгаа юм бол? Улирлын индексийн тохируулга гэдэг зүйлийг хэлж байна. Хуучин яг өмнөх

Тавантолгойн Чалкотой хийж байсан 10 хэдэн жилийн өмнөх гэрээний үнэ 70 доллар байсан. Энэ бол зөвхөн 4 дүгээр давхаргын буюу Цанхийн 4 дүгээр давхаргын нүүрсний үнэ, нүүрсэнд хамаарч байсан үнэ байгаад байгаа юм. Тэгэхээр одоо та бүхэн яг ордоосоо хамаараад, давхаргаасаа хамаараад яг тус бүрдээ чанараасаа хамаараад тус бүрдээ өөр, өөр үнээр тохирч чадаж байгаа юу? Тус бүрдээ энэ бол өөр, өөр үнэ цэнтэй байх ёстой асуудлууд нэгд орж байгаа, орох ёстой гэдэг асуудал байгаа.

2-т энэ нүүрсний үнэ бол чанар үзүүлэлт энэ ордныхоо давхаргаас гадна тухайн үнэ тогтоох аргачлалаасаа хамаарах асуудал байна. Үнэ тогтоох аргачлалаа яг яаж хийж байна вэ? Хуучин миний санахын өмнөх 10 хэдэн жилийн өмнөх Чалкон хэлэлцээрийн хүрээнд Хятадын 4 индексийн дунджаар улирал бүрийг тогтоодог байсан. Ингээд тухайн үед тогтоож байсан тэр үнийн аргачлалаас буруу санаагүй бол 1, 2 индексүүд нь байхгүй болчихсон. Тэгэхээр яг ямар бирж болоод яг ямар индексийнх нь дунджаар тогтоох ийм тохируулга механизм дээр та нар тохирч байгаа юм бэ? Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм.

2 дахь зүйл, энэ гишүүд хэлж байгаа зүйлийг би тодруулж асуумаар байгаа зүйл бол нүүрсний үнээс гадна үндсэндээ бид нүүрснийхээ үнийг өндөрт байлгах гээд, олборлолтоо чанартай сайн нүүрс байнга мэдээж худалдан авагч тал бол дандаа чанартай сайн нүүрсийг л хямд үнээр авъя гэж хүснэ. Гэтэл эсрэгээрээ бид энэ уурхайгаа хүчин чадлыг нь бүрэн дүүрэн ашиглая. Ямар нэг байдлаар сорчлохгүй байх асуудлыг хөндөж тавиад байгаа. Сүүлийн 10-аад жилийн хугацаанд бид Цанхи, Бортээгээ ашиглаж байгаа. Тэгээд энэ бол үндсэндээ аваад үзвэл Тавантолгой 8,1 тэрбум тонн нүүрсний нөөцтэй гэж авч үзвэл Цанхи өөрөө 50 хувь нь бараг шахуу байгаа 3,9 тэрбум. Бортээг өөрөө 2,4 тэрбум байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ бараг нийт нүүрсний чинь ордын 70, 80 хувь нь энэ 2 гол газраасаа бүрдэж байхад дахиад нэмж уурхай талбайг хөгжүүлэх, шинээр олборлолтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг асуудлыг дахиад 2 юу гэдэг юм уурхай дээр хүчин чадлаа нэмэгдүүлэх олборлолтыг хийнэ гэдэг асуудлыг чинь би гайхаад байгаа юм.

Тэгэхээр энэ нь өөрөө Ончхараат болоод Бортолгой гэдэг асуудлыг та хэд нэмж ярьж байна. Энэ 2 нийлбэл яах вэ нийлбэр дүнгээрээ 1 тэрбум тонн нүүрсний ийм асуудлууд байгаа юм. Тэгэхээр одоо байгаа Тавантолгой дээр дийлэнх 80, 90 хувийг нь ашиглаж байж яагаад дахиад нэмж оруулах асуудлыг тавьж байгаа юм бэ? Эсвэл өнгөрсөн 10 хэдэн жилийн хугацаанд угаасаа л бид нарын том алдаа маань мэргэжлийн бус удирдлагыг тавьснаасаа үүдээд дандаа сорчилж орж ирж явж байсан. 3, 4 дүгээр давхаргынхаа нөөцийг дандаа түлхүү олборлосон. Ингээд хөрс хуулалт талаасаа хөрснийх нь хоцрогдол ихтэй байгаад байгаа. Би буруу санаагүй бол 40 сая м³-ийн хөрсний хоцрогдолтой явж байгаа гэсэн мэдээллийг авч байгаа. Энэ нөхцөл байдлууд маань ямар байна вэ?

Бид бүхний алдаатай менежмент, үйл ажиллагаанаас хамаараад одоо бид дахиад 70, 80 хувийнхаа ашиглаж байгаа энэ ордоосоо нэмж үлдсэн юу гэдэг юм 10, 15 хувь руугаа орох ийм уурхайн зохицуулалтыг хийж байгаа юм уу? Одоогийн Цанхи болоод Бортээг дээрх энэ уурхайн үйл ажиллагаа ер нь яаж явж байгаа юм бэ? Энэ дээр нэг мэдээлэл өгөөч гэдэг зүйл хэлэх гээд. Ингэж байж юу гэдэг юм бид нарын чинь энэ төслөөс хүртэх үнэ цэн, үр өгөөжийн асуудал үндсэндээ би гол

үндсэн 2 асуудал эндээс л гарч ирэх гээд байгаа юм. Энэ дээр нэг мэдээлэл өгөөч гэсэн юм. Хэн хариулах вэ? 5 номер.

Ц.Туваан: Тэмүүлэн даргын асуултад би эхэлж хариулаад, дараагаар нь ЭТТ компанийн гүйцэтгэх захирал, дараагаар нь манай яамны газрын дарга тэр юуны хөрс хуулалтын хоцрогдолтой холбоотой, амны хүчин чадал нэмэхтэй холбоотой асуудал дээр хариулна.

Бид бүхэн мэдээж улсынхаа эрх ашгийг, дээрээс нь сорчлохгүй байх, бүгдийг нь борлуулах гэдэг энэ зүйлүүдийг нэлээн ярьж байгаа. Тэгээд энэ асуудал түрүүний хэлсэн 3 дугаарт нь орж ирэх тэр нөгөө компани хоорондын гэрээний асуудал дээр нэлээн нарийн заагдаж орж ирнэ. Үнэ яаж тогтож байгаа үнийн асуудлыг Мөнхжаргал дарга ойлгомжтой тайлбарлаад өгчих. Бид эндээс тодорхой нүүрснүүдийг коксжих, 1/3 нь коксжих, эрчим хүчний нүүрс гурваа тус тусад нь тодорхой процентолж буюу 55, 35, 10 гэсэн ийм хувиар өөр, өөр үнээр борлуулахаар ярьж байгаа. Тэгэхээр бүх нүүрснээс тодорхой хэсэг нь ороод борлуулалтад гарна.

Дээрээс нь энэ давхаргуудын нүүрсний тодорхой давхаргуудаас үлдэж байгаа нүүрсээ бид ЭТТ компани нийт хүчин чадлаараа 30 саяын, одоогоор яг ашиглалтад орж байгаа 10 саяын баяжуулах буюу угаах үйлдвэрээрээ угааж баяжуулаад борлуулна гэсэн ийм тооцоололтой ажиллаж байгаа. 7 номер.

Г.Тэмүүлэн: 7 номер.

Х.Мөнхжаргал: Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя. ЭТТ компанийн урт хугацаатай 4 гэрээ байдаг. Тус 4 гэрээний үнэ ерөнхийдөө Хятадын боомтууд дээрх 5 боомтын үнээс тогтож байгаа. Бид яах вэ энэ хэлэлцээрийн хүрээнд ерөнхийдөө 1 боомтын үнийг нэмье, гуравдагч улсын боомтын үнийг нэмж сагсанд оруулж тооцъё гэсэн саналыг одоогийн байдлаар тавьсан байгаа. Ерөнхийдөө яах вэ энэ хэлэлцээрийн явцад манай Хятадын тал хүлээж авах, авахгүйг сайн мэдэхгүй байна. Ерөнхийдөө үнэ өөрөө бид тогтоох ер нь боломжгүй. Хятадын яг боомтууд дээрх зарагдах үнэ дээр үндэслээд тогтоогдож байгаа үнийг бид авч нүүрсээ борлуулж байгаа. Тэгээд үнийн гол нь тохиргоо хийдэг улирал тутам хийдэг. Энэ улирал тутам үнийн тохиргоо хийж байгаагийн гол зорилго бол аль, аль талын нөгөө харилцан ашигтай байх зарчим шууд хамааралтай. Үнэ өсөхөд Монголын талд ер нь ашигтай. Ийм агуулгаар үнийн тохиргоо хийгээд явж байгаа.

2 ордын хувьд Бортолгой, Ончхараат гэсэн 2 орд ерөнхийдөө бид төлөвлөөд байгаа. Өмнө нь бүр 3 орд явж байсан. Бид нэг ордыг хассан. Одоо байгаа нөөц бололцоо буюу Цанхийн баруун, зүүн, зүүнээрээ бид хуучин явж байгаа амны гэрээ байгаа. Мөн биржийн арилжаагаа дэмжинэ. Яг тэр Цанхийн ордуудаасаа бид нөгөө талын борлуулалт явах ёстой. Тэр агуулгаараа шинэ уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг агуулгаараа ашиглаж байгаа. Бортолгой, Цанхи, Бортолгой, Ончхараат 2 нийлээд ерөнхийдөө юугаараа тэрбум орчим тооны нөөцтэй гэж одоогийн байдлаар гарсан. Тэгэхдээ нарийвчилсан хайгуул, судалгаа хийгээгүй. Энэ ордыг бүхэлд нь гарч байгаа нүүрс болгоныг өгөхгүй. Энийг та бүхэн ойлгох ёстой. Гэрээнийхээ тийм орд өөрөө ашиглагдаагүй, орд өөрөө одоо ямар нүүрс гарах хэмжээтэй, чанартай нүүрс гарах нь нарийвчилсан хайгуулаар тодорхойлогдоно.

Мөн гэрээний хүрээнд 20 сая тонныг 16 жил биш, 11 жил, 5 жил нь 27 сая, үлдсэн 11 жил нь 20 сая гэхээр 200 орчим сая тонн нүүрс худалдах, худалдан авах гэрээний асуудал. Энэ нь өөрөө борлуулалт хийгдэнэ. Бид борлуулсан нүүрсээ буцаагаад мөнгөн хэлбэрээр мөнгөөр зарна гэсэн үг. Ямар нэгэн оффтейк байхгүй. Бортээгийн хувьд ашиглагдаагүй. Бортээгийн уурхай ерөнхийдөө МТАС түншлэлтэй хийсэн гэрээний хүрээнд гэрээний эхлэх тэр ямар нэгэн юу хийгдээгүй. Одоо бид Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр зогсоох тэр тал дээр нь ажиллаж байгаа байгаа. Энэ тус хэлэлцээрт ер нь Бортээгийн уурхай хамааралгүй байгаа.

Г.Тэмүүлэн: 9 номер.

Г.Намчинсүрэн: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам Намчинсүрэн. Тавантолгойн ордын нөөц өнгөрсөн онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэгдсэн. Энэ дээр нөөцийн хэмжээ 8,1 тэрбум тонн гэж бүртгэгдсэн байгаа. Яг одоогийн байдлаар Цанхийн Оорцог, Бортолгой, Ончхараатын хэсэгт нарийвчилсан хайгуул хийгдээгүй. Зүгээр Ончхараатын хэсэг дээр 1988 оны бүртгүүлсэн нөөцийн хэмжээнд 785,9 сая тонн нүүрсний нөөц, Бортолгойн хэмжээнд 267 сая тонн нөөц. Энийг геологийн нөөцөд хамруулж, 8,1 тэрбум тонндоо тооцсон байгаа. Цанхийн хэсэг дээр 3,8 тэрбум тонн, Оорцог дээр 645 сая тонн, Бортээгийн хэсэг дээр 2,5 тэрбум тонн нөөц нийт хэсэгчлэн бүртгэгдсэн байгаа.

Г.Тэмүүлэн: 9.

Г.Намчинсүрэн: Ордын дундаж хөрс хуулалтын коэффициент 5,5 хавьцаа байдаг. Одоогоор ЭТТ жилдээ 150 сая м³ уулын цулын ажлыг гүйцэтгэж байна. Энэ хүрээнд хөрс хуулалтын дундаж коэффициент 5-тай байгаа. 30 орчим сая тонн нүүрсийг жил бүр олборлож, экспортод гаргаж байна.

Г.Тэмүүлэн: Энэ асуудлуудыг бид ер нь зүгээр яагаад санаа зовоод, Тавантолгой дээр ач холбогдол өгөөд, алдаа мадаггүй гэрээ хийх ёстой гэдэг асуудал маань үндсэндээ хүссэн, хүсээгүй л Монгол Улсын энэ төсөв санхүү чинь, эдийн засаг чинь уул уурхайгаас хамааралтай. Бараг 90-ээс 95 хувь нь. Энэ дотроо хамгийн гол ерөөсөө төсвийн орлого бүрдүүлж байгаа аж ахуйн нэгж бол ЭТТ нүүрсний уурхайнууд байгаад байгаа юм. Тэгэхээр ямар нэг байдлаар энэ төсөв санхүү өөрөө тогтвортой байх ёстой, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ёстой гэдэг үндсэн дээр болгоомжилж ямар нэг алдаа мадаггүй гэрээ хийгээсэй гэсэн хүсэл байгаад байгаа юм.

Тэгээд энэ дотроо бид бүхний хувьд энэ төслийн эдийн засгийнх нь үр ашиг, төслийнх нь үнэ цэн, үр өгөөжийг сайжруулъя гэдэг асуудлыг ярих юм бол Тавантолгой компанийн үйл ажиллагааг ярихаас арга байхгүй. Компанийн засаглалыг ярихаас өөр арга байхгүй. Би магадгүй буруу санаагүй бол борлуулах болон олборлох нэг тонн нүүрсэнд ноогдох өртөг өөрөө бусад хувийн хэвшлийнхнээс өндөр байгаад байгаа юм. 220 мянган төгрөг буюу нэг тонн тутамд байгаад байгаа юм. Тэгэхээр энийг зайлшгүй энэ ирэх жилүүдийн хугацаанд энэ компанийнхаа засаглалыг сайжруулж бууруулах шаардлага байна. Энэ дээр нэг тайлбар мэдээлэл өгөөрэй. Одоо явц ямар байна, ямар арга хэмжээ энэ дээр авч байна.

2-т гишүүдийн хэлж байгаа зүйл. Сая 2024 оны буюу одоогоос жилийн өмнөх 1 сарын 16-ны 9 тоот Улсын Их Хурлын тогтоолоор ямар нэг байдлаар энэ компаниас компанийн үйл ажиллагаанд хамааралгүй хөрөнгө оруулалт, төслийг санхүүжүүлэхгүй байх, хориглох гэдэг асуудлыг тогтоолоор чиглэл өгсөн байгаад байгаа. Та бүхний орж ирсэн энэ зээлийн Засгийн газар хоорондын хэлэлцээр дээр энэ хот байгуулалт, орон сууцжуулалт, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана гэдэг зүйл орж ирж байгаа. Энэ ямар нэг энэ нүүрсний гэрээгээр оффтейк хийх асуудал байхгүй биз дээ? Дахиж баталгаажуулж асууя. Яг албан ёсоор хариуцлагатайгаар энэ асуудлыг хэлээрэй. Энэ бол төлбөрийнх нь нөхцөл нь бэлэн мөнгөөр байх ёстой гэдэг асуудлыг онцолж тодруулж асуух гэсэн юм. 5 номер. 5.

Ц.Туваан: Тэмүүлэн дарга маш чухал асуудлыг ярьж байна. ЗГ дээр 2 ч удаа ЭТТ компанийн удирдлагын менежментийг сайжруулах, мөн сүүлийн үед Учрал сайд ахлаад энэ төрийн өмчийн компанийн өгөөжийг нэмэгдүүлэх энэ асуудал хуульчлагдахаар ингээд яригдаж байгаа. Тодорхой хэлбэл ЭТТ компанийн удирдлагын менежментийн багийг гадаадын баг, Монголын багтай хамтарч удирдах ийм төслөөр төслийн эхний байдлаар ЗГ-ын хуралдаан дээр танилцуулагдсан байгаа. Тэгээд ер нь энэ хувилбаруудыг сонгоод, удахгүй шийдэгдэх ийм тал руугаа явж байгаа гэдгийг хэлье.

Дээрээс нь ЭТТ компани сая манай газрын даргын хэлснээр ойролцоогоор 150 орчим сая уулын цулын ажил хийж байгаа. Энэ дээр бидэнд өгсөн мэдээллээр 1м³ уулын цулын ажил 14 мянган төгрөгийн өртөгтэй. Ингээд 5-аар бодвол нэг тонн нүүрсний яг өөрийн гаргаж байгаа өртөг 70 орчим мянган төгрөгийн зардлаар босож ирж байгаа гэсэн ийм тооцоололтой явж байгаа. Түрүүний хэлсэн Улсын Их Хурлаас баталж өгсөн 58 дугаар тогтоолоор баталж өгсөн үндсэн чиг дотор энэ хот байгуулалт, дэд бүтэцтэй холбоотой ийм томоохон асуудлууд орсон. Мөн энэ хэлэлцээртэй хамт батлагдах протокол дээр дараагийн асуудлууд нь тодорхой асуудлууд нь орсон. Энэ бүх зүйлүүд 2 улсын хоорондын хамтын ажиллагаа, ЗГ хоорондын хамтын ажиллагаа гэсэн хүрээнд ойлгогдоно гэж хэлье. Ямар нэгэн нүүрсээр эдгээр бүтээн байгуулалтуудын төлбөрийг буюу оффтейк байдлаар хийхгүй гэдгийг албан ёсоор хэлье. Баярлалаа.

Г.Тэмүүлэн: Баярлалаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу, нэрсийг авъя? Батсүмбэрэл гишүүнээр тасалъя. Шижир гишүүн үг хэлнэ.

Ө.Шижир: Бүгдэд нь өдрийн мэнд. Энэ саяын гишүүдийн асуултад асуугаад байгаа зарим зүйл чинь бид нарын нөгөө 12 сарын 27-нд батлаад өгчихсөн 58 дугаар тогтоол дээр чинь байгаа шүү дээ. Тэр хот байгуулалттай холбоотой, дэд бүтэцтэй холбоотой гээд. Тэгээд яах вэ энэ тогтоол дээр байхгүй ганц нэг заалт байгаа сая манай Жаргалан гишүүн хэлж байна. Бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд Хятадын ААН-ийг арилжааны зарчмаар оролцохыг дэмжиж, таатай нөхцөл бүрдүүлнэ гэдэг энэ үг энэ тогтоол дээр байхгүй. Ийм агуулга энэ тогтоол дээр нэг ч байхгүй. Тэгэхээр энэ чинь өөрөө энэ хэлбэрээрээ орвол тогтоол зөрчсөн, Улсын Их Хурлаас баталсан тогтоолыг хэлэлцээрийн явцдаа зөрчсөн ийм хэлбэр болно шүү. Тэгэхээр энэ дээр Гадаад яам илүү анхаарна биз. Цаад талдаа хэлэлцээр хийхдээ.

Тэгэхгүй бол нөгөө бид чинь Их Хурлаас 107 гишүүн оролцож сууж байгаад 107 гишүүний ирцтэйгээр баталчихсан юм байна лээ шүү дээ 70 хувийн, 70 хувиар энэ тогтоолыг чинь. Тэгээд энэ тогтоол батлагдсан хүрээнд энэ хэлэлцээр явагдах ёстой. Тэгтэл энэ хэлэлцээрт одоо энэ орж ирж байгаа хэлэлцээрт тогтоолд суугаагүй нэг ийм өгүүлбэр байна шүү. Энийгээ анхаарахгүй хэдүүлээ Их Хурлын тогтоолыг зөрчсөн хэлбэр лүү орно шүү.

Г.Тэмүүлэн: Батсүмбэрэл гишүүн үг хэлье.

Н.Батсүмбэрэл: Түрүүн Эдийн засгийн байнгын хороо дээр асуултаа асуугаад, саналуудаа хэлсэн. Гол саяын гишүүдийн яриад байгаа тэр нөгөө өмнөх бид энэ гэрээтэй холбоотой асуудлыг хэлэлцсэн байж байгаа. Тэнд орсон асуудлууд, тэр бусад боомтуудыг нээх асуудал, тэр говийн усжуулалтын асуудал, орон нутгийн оролцооны асуудал гээд олон асуудлыг цаашид яг хэрэгжилт дээр нь анхаармаар байгаа юм. Тэгээд энийг Эрдэс баялаг, аж үйлдвэр, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам маань нэлээн анхаарч ажиллах шаардлагатай байгаа. Цаашдаа ярьж байгаа эхний ярьсан ярианаасаа арай өөрөөр асуудал орж ирдэг баймааргүй байгаа юм. Бид энэ чинь 10 гаруй жил зогсчихсон, муу, сайнаараа хоорондоо ярилцчихсан нэг том төслийг урагш нь явуулъя гэж Их Хурал дээр нэлээн нэгдмэл байр суурьтай байж байгаа.

Гэсэн хэдий ч энэ дотор нь ярьж байсан тэр Шивээхүрэнгийн боомт, Бичигтийн боомт, бусад тэр боомтуудыг оруулах асуудал маань орхигдчихсон байж байна. Говийн усны асуудал байж байна. Үнэхээр тэр бодит байдал дээрээ ЭТТ компани баяжуулах үйлдвэр барьчихсан, усны нөөцийн асуудал яригдаж л байх жишээний. Гашуунсухайтын боомт дээр алсаас 40, 60км-ийн зайнаас ус зөөдөг асуудал байж л байна. Ингээд энэ том асуудлуудаа энэ дээрээ оруулж, хөндөж явах ёстой байгаа юм. Тэгээд энэ асуудлуудыг холбогдох яам маань анхаарч ажилламаар байгаа юм.

Тэр тодруулах шаардлагын хувьд тэр нэг сэргээгдэх эрчим хүчний асуудал байгаад байгаа юм. Тэгээд сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж экспортолно гэхихсэн гэдэг бол манай талаас биш юм шиг байгаа юм харахаар. Тэгэхээр сэргээгдэх эрчим хүчээ бид экспортолно гэж тайлбарлаад байгаа юм. Энийгээ яг тодорхой тайлбар нэг жоохон тусгаж өгмөөр харагдаж байгаа. Гадаад яам энэ дээр нэлээн тодорхой байр суурьтай баймаар байгаа юм. Одоо энэ бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо. Гадаад яамнаас асуухаар тодорхойгүй хариулж байна лээ. Монгол Улс орны, Монгол орны язгуур эрх ашигт, Монголын үндэсний аюулгүй байдалд, Монголчуудын эрх ашигт нийцсэн үү гэдэг асуултыг Гадаад яам ямар нэгэн маргаангүйгээр хариулж чаддаг байх ёстой гэж би энийг шаардаад байгаа юм. Гэтэл харамсалтай нь Гадаад яамнаас төлөөлж байгаа хүн энэ дээр хариулт байхгүй. Ийм байдалтай юмнуудыг нэлээн сайн ярьж, анхаарч ажилламаар байгаа.

Тэгээд энэ Байнгын хорооны дарга, ажлын алба яахад бол энэ өмнө нь бид 12 сард хэлэлцсэн асуудал, одоо ярьж байгаа асуудал 2-т зөрөө байгаа юм бэ? Энийг дүгнэлт гаргамаар байгаа юм. Байнгын хороо өөрөө. Цаашдаа энэ чинь өөрөө жишиг болж болохгүй. Бид ингээд энийг дэмжээд явж таарна. Гэхдээ болдог юм гэдэг байдлаар жишиг явж таарахгүй.

3 хэл дээр энэ гэрээ бичигдэж байгаа юм байна лээ. Бидэнд тараагдсан нь 2 хэл дээр байгаа. 3 дахь хэл дээр байгаа албан эх материал яагаад бид нарт тараагдахгүй байгаа юм бэ? Тэгээд маргаан үүсвэл англи хэл дээрх эх үүсвэр, сурвалжийг авна гэхчхэн байж байгаа. Яг нөгөө Аюулгүй байдлын байнгын хорооны чиг үүрэгт энэ хамаарч байгаа биз дээ. Тэр заалт дээр байж байгаа шүү дээ. 3 хэл дээр байна. 3 хэл дээр байгаа мөртөө 1 хэл дээрх материал нь бидэнд байхгүй байна. Маргаан гарвал англи хэл дээрх хувилбараа барина гээд байдаг. Тэгээд энэ ажлуудаа сайн анхаарч, тал бүр дээрээ, дор бүрнээ ажил хариуцаж байгаа хүмүүс нь явмаар байна. Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд энийгээ явуулчих гээд байдаг, доор нь салбар ажил хариуцаж байгаа хүмүүс нь энийгээ бүрэн гүйцэд хиймээр байгаа юм. Бүрэн гүйцэд ажил хариуцаж байгаа хүмүүс хийхгүйгээс болж байж, нэгэндээ итгэж найдаж байгаагаас болж, нэгэндээ эсхүл нэг ажил дээрээ овоорч байгаагаас болж энэ ажлууд унадаг ийм тохиолдлууд бий.

Тийм учраас болж байна, бүтэж байна гэдгийг Ерөнхий сайддаа ч, Их Хуралдаа ч хэлэхгүйгээр, болохгүй, бүтэхгүй байгаагаа ярьж хэлж байж бид асуудлаа урагш нь явуулмаар байгаа юм гэдгийг анхаарч ажиллаарай гэж зориуд би онцолж хэлье. Саяын асуудлууд дээр Байнгын хороо ч анхаарах байх, Байнгын хорооны ажлын алба ч анхаарах байх. Тэгээд энэ хариуцаж байгаа хүмүүс ч анхаарах хэрэгтэй. Ийм, ийм асуудлууд яг чиг үүргийн хувьд байна шүү гэдгийг хэлье.

Г.Тэмүүлэн: Энхтүвшин гишүүн үг хэлье.

Д.Энхтүвшин: Би нэг юмыг тодорхой хэлье. Ганцмод-Гашуунсухайт боомтын энэ хил холболтын төмөр замыг дэмжиж байгаа. Энийг угаасаа бид хэд Монголчууд өөрсдийнхөө ТӨК-ийнхаа мөнгөөр энэ хөрөнгө оруулалтыг нь өөрсдөө хийе гэж байгаа. Тэгээд нөгөө талд нь энэ гэрээ хэлцлийг гол нь үр ашигтай хийгээд ир гэж явуулсан чинь нөгөө ухаангүй ноёнд урагшгүй албат гэдэг шиг, болдоггүй бор өвгөний нөгөө нисдэг морь мэт, морь гэдэг шиг Монголын талд ноогдох давуу талыг нь сайн болгоод ир гээд ирсэн чинь гэрээнд байхгүй заалтуудыг нэмээд, Хятадын талд ашигтай ийм заалтууд оруулаад ирсэн байна. Тэгэхээр энэ 8 зүйл байна. Энэ заалтыг оруулахгүй бол, өөрчлөхгүй энэ хэлэлцээрийн төслийг дэмжих боломжгүй. Тэгээд илүү сайжруулах шаардлагатай гэж бодож байна.

1 дүгээрт Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр энэ гэрээг хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээр гэж байсныг энэ одоо оруулж ирсэн төсөл дээр болохоор дээр нь нэмээд нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадал гэж оруулж ирсэн байна. Энийг Улсын Их Хурлын тогтоолын төсөл дээр болгомоор байна.

2 дугаарт нь энэ гэрээний талууд дээр Хятадын талаас Чайна Энержи хөрөнгө оруулалтын компанитай хамаарал бүхий хуулийн этгээдтэй хамтран ажилладаг Хятадын санхүүжилттэй гэхээр ер нь Хятадын бүх компаниудыг энд оруулж ирэх гэж байна. Гэрээний тал дээр. Тэгэхээр энийгээ өөрчил. Ийм ерөөсөө яригдаагүй 2 дугаарт нь.

3 дугаарт нь энэ урьдач нөхцөл гэдэг юм. Гэрээн дээрээ ч гэсэн үзэл баримтлал нь 3, 1 гэж байгаа гурвуулаа зэрэг явах ёстой байтал нүүрсний

худалдаа хийж байж, уурхайн гэрээ хийж байж энэ төмөр замын асуудлыг чинь ярина гэсэн ийм урьдач нөхцөл гэж орсон байна. Энийгээ өөрчил.

4 дүгээрт нь энэ нүүрсний гэрээтэй холбоотой заалт дээр үнэ, үнээ тооцож байгаа FCA уурхай ам гэж байгаа. Өөрөөр хэлбэл Монголчуудад нүүрс тээвэр хийж сурчихсан, хөрөнгө оруулалт хийчихсэн, уурхай хийгээд сурчихсан энэ бололцоо боломжуудыг Хятадуудад ингээд өгөх гэж байна. Тэгээд энэ үнийн нөхцөлөө, дээр нь энэ дээр тэр сая амаараа болохоор эрчим хүчний нүүрс орчихсон гэж байна. Тэр заалтуудаа оруулах хэрэгтэй байна.

5 дугаарт нь энэ Хятадын компаниудад энэ ААН-ийг арилжааны зарчмаар Хятадын компаниуд оролцохыг дэмжинэ, тэгээд таатай нөхцөл бүрдүүлнэ. Энэ заалт тогтоолын төсөл дээр байхгүй. Энийгээ ав.

6 дугаарт нь энэ Хятадын эрчим хүчний сэргээгдэх эрчим хүчний компаниудыг дэмжих ийм заалт орчихсон явж байх шиг байна. Тэгэхдээ ийм зүйл тогтоолын төсөл дээр байхгүй. Энийгээ ав.

7 дугаарт нь энэ нууцлалтай холбоотой асуудал байна. Энэ гэрээ өмнө үе үеийн Тавантолгойн компаниуд дээр хулгай гарч байсан, авлигын асуудлууд гарч байсан. Тэгэхээр энийг тойроод ийм асуудал болж магадгүй учраас энд нууцлаад байх юм байхгүй. Хэрвээ Хятадын тал үнэхээр нууцалъя, нууцлах хэрэгтэй гэж бодож байвал гэрээгээ ерөнхий хийгээд, ийм нарийн зохицуулалттай холбоотой заалтуудаа өөр тусдаа ил болгодог гэрээгээр зохицуул гэдэг ийм заалт байна.

Дараагийн 8 дахь асуудал нь авлигатай холбоотой заалт оруулмаар байна. Энэ нэмэлт заалт дээр хэрвээ ямар нэгэн байдлаар Хятадын ТӨК ч юм уу, Хятадын талаас Монголын ТӨК энэ улс төрийн албан тушаалтан, нам, бүлгүүдэд тодорхой хэмжээний авлигал өгсөн бол энэ гэрээ цуцлагдах ийм нөхцөлд ийм заалт оруул. Тэгэхгүй энэ хийж байгаа үйл явцуудыг нь харахаар л энэ гэрээг хийхийн өмнө маш том PR акцууд явсан. Энийг эсэргүүцэх хүн байхгүй байхад чинь эсэргүүцэх гэж байгаа юм шиг хүчээр хийх гэж байгаа юм шиг ийм асуудлууд явсан. Энэ гэрээтэй холбоотой асуудлууд дандаа шинэ жилээр ч юм уу, чуулган завсарласны дараа ч гэдэг юм уу ийм завсрын үеүдэд ингээд орж ирж байна. Тэгэхээр энэ дээр би хувь хүнийхээ хувьд хэлье над руу нэлээн дайрсан. Би бол энэ төслийг төмөр замыг явуулахыг дэмжиж байгаа. Би улсыг эрх ашгийг тавина. Ямар нэгэн бүлэг эрх ашгийг хамгаалж байгаа юм байхгүй. Хэрвээ миний эсрэг юм хийгээд байгаа тэр бүлэг хүмүүс өөр энэ хардахаар байхгүй, хулгай нүүрсний хулгай улам томроод бүүр томоор нь хийх гэж байгаа юм биш биз дээ гэсэн. Тэгэхээр ийм тийм санаа бодолтой хүмүүс бол айхгүй шүү гэдгээ хэлье.

Г.Тэмүүлэн: Анар гишүүн үг хэлье.

Ч.Анар: Энэ гэрээ явах ёстой. Цаашлаад энэ бид энэ яаралтайгаар энэ ЗГ хаврын чуулганаасаа өмнө энэ асуудлаа шийдчихмээр байна. Гэхдээ ингээд нөгөө гэрээнүүдийг ингээд яаралтай горимоор нөхцөл байдал яриад улс хэцүүдлээ ингэж орж ирээд дундуур нь ингээд сэжиг бүхий заалтуудтай орж ирээд Их Хурлыг шахаад байдаг юм аягүй их ажиглагддаг юм байна. Тийм. Тийм учраас миний зүгээс яах вэ энэ улс орны чухал шаардлагатай хэлэлцээр учраас зарим нэгэн заалтуудаа өөрчлөхгүй бол энэ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүний зүгээс бид гишүүд энэ дээр юун дээр анхаарах ёстой вэ

гэхээрээ Монголын талаас энд оролцогч нь зөвхөн төр, хувийн хэвшил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн ажиллагаа гэдэг заалт бид зарчим энэ ЗГ иржээ эд нар маань байхгүй.

Нөгөө талаасаа Чайна Энержи маань байж болно. Хамтран ажилладаг Хятадын санхүүжилттэй байгууллага ААН гээд дахиад Хятадын ААН-ийг арилжааны зарчим оруулж таатай нөхцөлийг бүрдүүлнэ гэж байгаа юм. Тэгэхээр энэ өнөөдрийн нөхцөл байдал Монголын заяа их гэдэг шиг янз янзын бүлэглэл нөхцөл байдал, улс төр, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаар явсаар байгаад өнөөдөр энд ирсэн. Гэхдээ энэ маань цаашдаа харилцан ашигтай Монгол талдаа ч ашигтай, Хятад талдаа ч ашигтай байх ёстой. Тэгэхээр миний хэлж байгаа санал нь Байнгын хорооны гишүүд ЗГ-ын зүгээс Туваан сайд жижиг сажиг Их Хурлын тогтоолтой нийцүүлж, зарим асуудлуудаа хэлэлцээд дахиад Байнгын хороо руу оруулж ирвэл яасан юм бэ? Тэгвэл бид энийг дэмжье гэж байгаа. Гэхдээ зарим нэгэн жижиг сажиг Их Хурлын гаргасан тогтоолтой нийцүүлж оруулж ирэхийг хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Батбаатар гишүүн үг хэлье.

Б.Батбаатар: Хэлэлцэх асуудалтай холбоотой нөгөө хэлэлцэх асуудал дээрээ санал байна уу гэдэг байдлаар дэгийн маягаар энийг заавал санал хураалт руу оруулах нь зөв юм уу, буруу юм уу гэдэг дээр эргэлзэж байна. Ер нь ЗГ талын мэдээлэл болон тодруулах зүйлүүд шаардлагатай байгааг үндэслээд энэ санал хураалтыг хойшлуулах, үгүй бол Бүлгийн дэд даргын хувьд Жаргалан завсарлага авдаг юм уу нэг тиймэрхүү байдлаар хэсэг хойшлуулсан нь дээр байх. Энийгээ ярилцаад энэ, энэ зүйл заалтууд дээр нь ингэе тэгье гээд, одоо шууд санал л хураасан тохиолдолд дэмжигдэж магад, дэмжигдэхгүй байж магад. Дэмжигдэхгүй бол энэ зөвшилцөл чинь зогсчихно. Гэрээний асуудлууд маань ингээд тэр чигээрээ явчихна. Хаврын чуулган дээр очоод гарын үсэг зурсан гэрээ соёрхон батлагдахгүйгээр нурах аюул үүснэ.

Энэ Ганцмод-Гашуунсухайтын боомт төмөр замаар холбогдож, Монголын үүц нь нээгдсэн энэ нүүрс хамгийн ихээрээ чадах чинээгээрээ зарагдах нь Монгол Улсад хэрэгтэй. Гэхдээ энэ ажлаа хулгай хийх боломжийг үүсгэсэн байдлаар, дээрээс нь тодорхойгүй нөхцөл байдлыг ирээдүйд бий болгож магадгүй үг үсгийн заалттай ингэж хийж болохгүй байх. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо манай Байнгын хорооны нэр нь өөрөө аливаа зүйлийг сайн нягтал гэдэг л нэр шүү дээ. Тийм болохоор энэ тал дээр жаахан анхаарч санал хураалтыг явуулмаар байна хойш нь татаж.

Г.Тэмүүлэн: Болормаа гишүүн үг хэлье.

Э.Болормаа: Гашуунсухайт-Ганцмодны төмөр замын холболт, цаашлаад нүүрсний худалдаалах гэрээ, 2 орны ЗГ-ын хоорондох энэ хэлэлцээрийг оруулж ирж байна. Өнөөдөр 2025 оны 1 сарын 27-ны өдөр. Яг 4 жилийн өмнө Оюун-Эрдэнэ сайд Ерөнхий сайдаар томилогдож тухайн жил 2021 онд нүүрсний экспорт гэхэд дөнгөж 16 сая тоннтой байсан бол энэ жилийн 2024 оны өнгөрсөн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэл 80 гаруй сая тонн болоод явж байна. Тухайн үед 2021 онд юун төмөр зам холбох байтугай холбох төмөр зам нь баригдаж дуусаагүй, ковидын ид дунд үед, дээрээс нь бид дотооддоо энэ нүүрлээд байгаа нүүрсний хулгай гэгч зүйлстэй маш хүчтэй, зоригтойгоор тэмцэж ирсэн. Өнөөдөр ийм хэмжээнд ярих

хэмжээний болтол нь авч ирсэн, олон удаагийн ажлын хэсгийн хурлууд, 2 талын хэлэлцээрүүд, Засгийн газрын ажлын үр дүнд ямар ч байсан өнөөдөр ийм түвшинд ороод ирж байгаад нь, мөн энэ сүүлийн ажлын хэсэг маш хурдтай ажиллаж, олон улс төрийн гацаанууд арилсан учир ингэж ажиллах боломж бүрдээд явж байгаад харахад баяртай байна.

Уг нь бид 2 компанийн хэлэлцээр 2 компанийн хооронд л явчих ёстой зүйл. Өнөөдөр ингээд Байнгын хороогоор ЗГ-аар, Улсын Их Хурлаар орж ирж байгаа шалтгаан нь өөрөө үндсэндээ Энхбаяр гишүүний түрүүний хэлсэн бид нүүрсний хулгайтайгаа ингээд тэмцэж байгаа л арга барил. 12 сард Их Хурлаар батлагдсан Улсын Их Хурлын тогтоолын хамгийн том ололт амжилт нь гуравдагч талын оролцоогүйгээр бид энэ хэлэлцээрийг хийнэ гээд өнөөдөр 2 компанийн хооронд хийнэ, 2 улсын төр хоорондоо хийнэ гэдэг ийм том ололт амжилттай хэлэлцээр явж байна. Үүний дараах гишүүдийн хэлж байгаа санал миний ч гэсэн санаа зовниж байгаа байдал энд бид Улсын Их Хурал дотор 126 гишүүн бол ямар ажил хэрэгчээр, ямар ашиг сонирхолгүйгээр энэ асуудалд хандаж байгаа нь ил байгаа болов уу. Ямар хурдтайгаар улс орныхоо хөгжлийг илүү хурдасгая, гацааг нь арилгая гэж тал талаас ухаан уралдуулж хандаж байна.

Харин аливаа нэг зүйл ажил хэрэг болгох гэж дараа нь өнөөдөр бид энэ дотор нэг юм батлаад л, маргааш төмөр зам баригдчихгүй, нэлээн олон шатын ажлууд болно. Тэнд маш олон дунд шатын ажлууд, хэлэлцээрүүд явагдана. Сая бид энэ олон нийтэд явагдаж байгаа аливаа хээл хахууль, байгалийн баялагтай зүйлсүүд ямар албан тушаалтнуудын оролцоотойгоор явдгийг харлаа шүү дээ. Газрын дарга нар, янз бүрийн агентлагийн дарга нар байсан хүмүүс. Тэгэхээр би энэ дээр ямар санал хэлэх гээд байна гэхээр одоо 2 компанийн хоорондох хэлэлцээр ороход Туваан сайд яг та ЗГ-ыг төлөөлж энэ хэлэлцээрт гарын үсэг зурах хүний хувьд үүн дээр эртнээс хулгайгаас сэргийлэх арга хэмжээнүүдээ авмаар байгаа юм. Тэрнээс биш сая Энхбаяр гишүүний хэлдэг шиг хулгай болчих вий гээд тэрнээсээ болоод бид ямар ч хөдөлгөөн хийхгүй зогсох биш, эхнээсээ энэ Эрдэнэс Тавантолгой дээр Авлигатай тэмцэх газрын төлөөллийг нь тэр ажлын хэсэгт нь эхнээс нь оруул, энэ хэлэлцээрт Гадаад яам илүү хариуцлагатайгаар оролц.

Сая Батсүмбэрэл гишүүн маш тодорхой зүйлүүдийг хэллээ шүү дээ. Гэх мэтчилэн ийм арга хэмжээнүүдээ авч ороосой. Бид Байнгын хороогоор одоо хэлэлцэж дуусаад, дахиж энэ яг 2 компанийн хоорондох хэлэлцээр бид нарт орж ирэхгүй, гишүүдэд орж ирэхгүй. Тэгэхээр эртнээс энэ дээр мэргэшсэн гишүүдийн төлөөлөл, мэргэжлийн байгууллагуудын яг энэ хулгайтай тэмцэх байгууллагуудынхаа төлөөллийг.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Болсон уу Болормаа гишүүн? Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Би түрүүн улс төрийн байр суурь илэрхийлсэн. Дахиад улс төрийн байр суурь илэрхийлье. Тэгээд энэ Улсын Их Хурлын танхимд Монгол Улсыг хөгжүүлэхгүй гэж байгаа нэг ч гишүүн байхгүй. Бүгд хөгжүүлье гэж байгаа, нүүрсээ заръя гэж байгаа, төмөр замтай больё гэж байгаа. ЗГ үйл ажиллагаандаа дүгнэлт хийгээсэй, энэ PR нь хэтрээд байна. Тэгээд энэ Улсын Их Хуралд нэг хэдэн нүүрсчдийн мафи байгаад, нэг бүлэглэл гээд. Тэгээд тэр нь гацаагаад байгаа. Туваан сайд алдагдсан боломжийн тухай ярьсан. Та чинь хэдэн их наяд төгрөгийн өнгөрсөн хугацаанд алдагдсан боломж байж, Монгол Улс, Монголын ард түмэн

хохирлоо гэж мэдэгдээд байгаа билээ. Хэн хохироосон юм бэ? Эзэн биетэй нэртэй нь ярь. Тэгээд эзэн биегүй, тэгээд янз бүрийн ийм төсөл гэрээ хэлэлцээр орж ирэхээр түүн дотроос нь асуулт асуунгуут л энэ нь нэг мафийн гар хөл ч юм шиг, PR нь дандаа тэгж явдаг. Юманд хэмжээ хязгаар гэж байдаг юм шүү. Тэгээд энэ жишээлбэл Чайна Энержигийн хэлэлцээртэй холбоотой Засгийн газар нэг захиалгат нэвтрүүлэг хийж бүх телевизээр цацлаа. Тэгээд энийг хөтөлж байгаа хүн нь Амундра. Амундра бол өнгөрсөн онд болсон тэр нүүрсний хулгайтай холбоотой сонсгол дээр гэрчээр дуудагдсан этгээд. ЭТТ-той холбоотой хамгийн том оффтейк гэрээг хийсэн компанийн захирал. Тийм хүн ЗГ-ын PR хийгээд сууж байгаа юм.

Тийм учраас би итгэхгүй байна гэж олон удаа хэлж байгаа юм. Бортээгтэй холбоотой Админералын ордыг яагаад энд авч үлдээд байгаа юм бэ гэдэг дээр би хардлагаа асуулт хэлбэрээр асууж байгаа юм. Одоо хүртэл ЭТТ компанийн удирдлагуудыг би сонирхлын зөрчилтэй байна гэж хараад байгаа юм. Нүүрсний хулгайтай холбоотой асуудал дээр хуруу байтугай хумс ч хөдөлгөхгүй байгаа. Харин тэнд холбогдсон нөхдүүд дандаа албан тушаал дэвшиж, шийдвэр гаргах түвшинд ажиллаад байгаа. Үг яриа биш үйлдэл харуулж байгаа. Би тэгэхээр үйлдлээр нь дүгнээд байгаа юм. Тэр үнийн асуудлыг яагаад энд тодорхой байдлаар оруулж ирэхгүй байна вэ хэлэлцээр дээр. Хэрвээ ард түмэн санаж байгаа бол энэ үнийг тогтоож байгаа асуудлыг яг бүтэн нэг өдөр ярьсан байхгүй юу. Яагаад хил дээр 100 доллар гарчхаад байгаа нүүрсийг та нар 60 доллароор гэрээ хийгээд байгаа юм бэ гэдгийг би ЭТТ-н бүх түвшинд асуугаад хариулт өгөөгүй. Серикжан гэж захирал мэддэг болж таарсан. Тэр нь бултсаар байгаад дууссан байхгүй юу. Одоо яг тэр аргачлалаараа үнэ тогтоох гээд байгаа байхгүй юу.

Г.Тэмүүлэн: Ганбат гишүүн үг хэлье.

Д.Ганбат: Би асуултаа асуусан. Тэгээд асуултаа асуухдаа Монгол Улсын эрх ашиг, Монголын ард түмний эрх ашигт нийцэж байна уу наад энэ Улсын Их Хурлын тогтоол, энэ гэрээ хэлэлцээр чинь гэж асуусан л даа. Тэгээд нийцэж байна, бид хариуцна энэ тэр гэж ярьж байгаа хүн ерөөсөө алга байна. Одоо уул нь 3, 4 яамнаас бүрдсэн яг энэ хэсэг дээр удаан ажилласан ийм хүмүүс энэ дотор сууж байх шиг байна. Гэтэл тийм хариулт алга. Тэгэх ч байх гэж би бодсон юм.

Нөгөө талаар яаж энэ Монголын ард түмнийг энэ 20, 30 жил ардчилал ялсан боловч яаж ядуу байлгаж чадаад байна вэ, энд үгүй мөн ухаан хэрэгтэй дээ гэж гаднын хүн хэлж байсан, хэлж байна лээ. Тийм байна шүү дээ. Уг нь өнөөдөр бид нэг хүнд ноогдох энэ ДНБ-ийг 20 мянган доллар болчихсон байна гээд ингээд яриад сууж байх ёстой байтал 10 мянга яаж хүргэх үү гээд байдаг. Тэгээд энэ Тавантолгойн бүлэг орд бол ёстой нэг бидний эцэг өвгөдөөс, бурхнаас бэлэг болгож өгсөн ийм орд. Тэгээд энэ хугацаанд бид яаж ашиглаж ирэв? Бүгд хулгай, авлига ийм юм нүүрлэж байсан. Гэтэл бид өрсөлдөх чадвар байна уу энэ нүүрсэн дээр, энэ зах зээл дээр, Хятадын зах зээл дээр, цаашлаад гуравдагч орны зах зээлд хүргэх. Яаж өрсөлдөх чадваргүй байлгах талаар л ингэж ажиллаад байх юм. Тэр хулгай зэлгий яривал дуусахгүй юм болно.

Хамгийн гол бодлого, шийдвэр гаргаж байгаа юм чинь энэ рүү чиглээд байна. Энэ зүгээр төмөр замын хил холболт биш байна. Мухар төмөр замаа ямар үнээр хил гаргаж байна вэ? Энийг бид тооцож харах ёстой. Хэн нэг нь тэгээд цаашаа ярина л даа. Монголын ард түмэн тийм өнөөдөртөө мунхарч байгаа

боловч маргаашдаа энэний учрыг олно. Их Хурлын өнөөдөр Аюулгүй байдлын байнгын хороон дээр байгаа гишүүд бол үнэхээр ажилд хэрэгч, зөв ярьж байна, ард түмнийхээ эрх ашгийн төлөө дуугарч байна. Бусад нь ямар байгааг би мэдэхгүй байна. Тэгээд бага дээр нь засаж залруулмаар байх юм. Ийм зүйлийг хэлж яриад байхад та бүхэн тэмдэглэж аваад, ойлгоод, энийгээ бага дээр нь засаж залруул. Энэ ордыг үр дүнтэй ашиглаад ингэж явах ёстой. Гэтэл тэр Хятадын тэр юмыг би очиж харсан шүү дээ, үзсэн. Тэр Чайна Энержигийн тэр Baotou Бугат хот дээр, Чайна энержигийн төв оффис дээр бүх юмыг хянаад сууж байдаг юм байна лээ. Ерөөсөө ямар машин гарч байна, хэн гэдэг жолооч явж байна, тэр далай дээр яваа усан онгоцоо хүртэл хянаж байна лээ. Тэнд бүх мэдээлэл байгаа.

Манай энэ авлигачид, манай энэ мөнгө төгрөг завшсан улсуудын. Тийм барьцаанд орчихсон бүлэглэл, тийм хүмүүс хийж байгаа бол хэцүү. Тийм хүмүүс олон байгаа. Хууль хяналтын байгууллагууд толгойг нь илээд л өнгөрөөж байгаа. Тэрний нэг илрэл нь Улсын Их Хурлаас шахаж шаардаад хэлээд байна шүү дээ. Наад авлигатай тэмцэнэ, авлига авсан бол энэ гэрээ хэлэлцээр цаашид ямар байх вэ гэдгийг ярина энэ тэр гэсэн ийм зүйл, заалтыг оруулж өг. Ганцхан талын ер нь Засгийн газар юундаа PR-даг юм. Хэн энэ сурталчилгааг явуулаад байгаа юм, ямар мөнгөөр санхүүжээд байгаа юм гэсэн зүйлүүдийг тодруулах хэрэгтэй. Энэ ордыг бид үр дүнтэй ашиглаад, 20 жил бид үр дүнтэй ашиглаж чадсангүй. 10 жилийн өмнө эхэлчихсэн төмөр зам өдийд Монгол Улсын төрийн мэдлийн болоод явж байх ийм боломж байсан уу гэвэл байсан. Гэтэл алга. Тэгээд ийм хүмүүсээр ажил хийлгээд, хариуцлага тооцохгүй ингээд яваад байхаар чинь дараа дараагийн ийм итгэл үнэмшил төрүүлэхгүй байна.

Тэгээд энэ юман дээр дуугүй байхаар ард түмэнтэй холбоотой, хүн болгонтой холбоотой, Монгол Улсын иргэн бүгдтэй нь холбоотой ийм зүйл дээр дуугарахгүй, хэлэхгүй байгаад эхлэхээр бид бүхний энэ бүх юм дуусаж байгаа нь тэр. Бид хэлэх гэж, ярих гэж, энэ буруу юмыг засаж залруулах гэж энд ирж сууж байгаа юм. Тэгээд энэ юмаа алдаа дутагдлаа зас. Тэгж байж наадхыг чинь дэмжинэ. Холбох нь зөв.../минут дуусав/

Г.Тэмүүлэн: Энэ чинь дэлгэц яагаад гаргахгүй болчхов уу. Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд холбох нь зөв. Ганбат даргын хэлж байгаа зөв. Тэгэхдээ ийм нөхцөл байдалд биднийг оруулсан гэдэг зүйл дээр нэлээн дүгнэлтээ хийж урагшлах нь уу даа гэж бодтол эцсийн мөч дээрээ тэр хүмүүс нь баатар мэт аашлаад, янз бүрийн PR хийгээд байгаад ерөөсөө ойлгохгүй байгаа. Монгол Улсыг өнөөдөр яг нэг хавханд орсон ангийн олз шиг болгосон хүмүүс нь, тэр анг үргээж байсан үргээлэгт нь явж байсан гаднын эрх ашигт үйлчилж байсан хүмүүс нь өнөөдөр энэ танхим чинь дархан эрхтэй сууж байгаа л даа. Бараг суухгүй байгаа, хуралдаа ирдэггүй юм. Ийм байдал руу аваачсан хүмүүс нь яг ЗГ-ын гишүүдтэй нийлж байгаад PR хийгээд, тэгээд энэ дээрээ харин ганц нэг зарчим ярьсан хүмүүсийг Хятадаар нь дуудаад ингээд байгаад дургүй хүрээд байгаа юм. Уг нь дэмжмээр байгаа байхгүй юу.

Тэгээд ямар бодолтой юм? Энд орж ирэхээрээ ингээд амаа үдүүлчихсэн юм шиг суугаад кнопдох ёстой юм уу, зөв зүйл дээр нь зарчим хэлье гэхээр. Өнөөдөр алдагдсан боломжийг Туваан сайд 18,5 тэрбум доллар гээд 10 жилийн хугацааг хэлсэн. Энэ 10 жилийн хугацаа дээр нэмээд энэ гэрээ байгуулагдвал 16 жилээр

бид хэд энэ бүлэг ордын тодорхой хэсгийг өгөх гэж байна. Ингээд тооцвол 30 жил Монгол Улсын эдийн засгийг хорлож байгаа хүнтэй ЗГ хэлэлцээр хийж байгаа хүмүүс та хэд нэг байгаа юм байна лээ. Та хэд их магтаад, Монголын аврал болсон юм байна гээд магтаад сууж байгаа юм байна лээ. Энэ дээр нь гайхаад байгаа байхгүй юу. Овоо юман дээрээ дүгнэлт хийгээд, энэ алдагдсан боломжийг араас нь явах юм байна, Монголчуудын энэ алдагдсан боломжийг олж ирэх юм байна, тэр буруу хүмүүс дээр нь энэ нөхцөл байдлыг үүсгэсэн хүмүүс дээр нь хариуцлага тооцох юм байна гэсэн чинь үгүй юм байна лээ.

Тэр нэвтрүүлгээр ерөнхийдөө бурхан юм уу хаашаа юм бэ. Тийм учраас өнөөдөр бүр хэлмээр байгаа юм. Тэгэхээр энэ хэлэлцээр хийж байгаа бол мэргэжлийн байх хэрэгтэй байна. Яг хэлэлцээртээ дамжуулж ийм нэг хачин утгагүй ийм юм хийдгээ боль. Тэгээд зохион байгуулалттай хүмүүс нь шууд ингээд бүлэглэн ажиллах хүчний бизнесийг дэмжье гэсэн хууль дээр нь Хятадаар нь дууддаг. Тэр хүмүүсийн харин удам судрыг би зэрэгцүүлээд тавивал би илүү Монголд гарна, би цэвэр Монгол гарна. Тэд нар бол 2 дахь үе дээрээ явж байгаа хүмүүс шүү дээ. Тэгчхээд бүгд Хятадын эсрэг энэ тэр гээд сонин юм ярьдаг. Хятадуудад энэ таатай нөхцөл байдлыг бүрдүүлсэн хүн нь хэн юм бэ? Ингэж ЗГ-ын хэлэлцээр хийж байгаа сайд нар ийм байдалтайгаар ийм PR хийх юм бол цааш цаашдын асуудлууд чинь мэдэхгүй. Тэгээд энэ дээр ер нь цаашдаа нэг хэлэлцээр дээр энэ дотоодын аж ахуйн нэгж байгууллагыг туслан гүйцэтгэгч энэ тэрээ оруулах асуудал энэ тэрийг яг таг тохирмоор байна. Түүн дээрээ тохирч байгаа, энэ дээрээ тохирч байгаа гээд нэг еэвэнгийн үлгэр үзүүлээд байгаа юм.

Би Туваан сайдыг заримдаа өрөвдөх юм. Бүх юмны нэг бантанг цэгцэлчихье гээд энэ бүх талын эрх ашиг дээр л яваад байх шиг байгаа юм. Тэгээд яадаг бол доо нээрээ. Энэ байдлаараа мэдэхгүй. Баттулга тэргүүтэй хүмүүс ингээд нэг ардын баатар, яршиг л байна шүү дээ. Тэр хүнд Монгол Улс ямар өртэй юм. Монгол Улсыг ингэтэл нь шавар шавхайтай хутгачхаад тэр хүнд ямар хэмжээний уучлалыг хүртэл PR-аар нэвтрүүлэг хийж үзүүлдэг юм. Ямар их даварчихсан юм, ямар их залуучууд Монголд энэ төрийн төлөө явж байгаа хүмүүсийг Хятад цусаар нь, Хятад цустай болгож харуулдаг юм. Ийм юман дээр ЗГ, төрийн байгууллагууд өөрсдөө оролцож та нар их зөв шийдвэр гаргасан гээд сууж байгаад би бүр эгдүүцээд ингээд байн, байн хэлээд байгаа юм. Энэ ашиггүй байдлыг үүсгэсэн хүн шүү. Өнөөдрийн энэ Монгол Улсыг хавханд оруулсан хүмүүс шүү. Аварсан биш.

Энэ хавхны нөхцөлд орсон учраас л ийм ундуй сундуй, нэг талаараа дандаа болгоомжилсон ийм л хэлэлцээрүүд гэрээний нөхцөлтэй хэлэлцээр л орж ирж байгаа шүү дээ. Гишүүдийн яриад байгаа нэг талдаа үнэн байхгүй юу. Тэгэхдээ та нарт энэнээс өөр гарц байхгүй. Тэгээд хожим нь тэр хэсэг бүлэг хүмүүсээс нэг хэсэг бүлэг нь дүүжлүүлэх юм байлгүй. Тэгээд нэг ийм том төсөл явуулахдаа харыг цагаанаар будаж өгдөг ийм заваан PR-аа одоо болиорой. Зөв зүгээр байгаа энэ хүмүүсийг оролдож Хятад болгох юм бол харин мэдэхгүй. Яг ийм технологиор ийм нэг заваан төсөл явуулдаг, гишүүдийг нэг ийм гарцгүй болгодог ийм заваан юмыг болиорой л гэж хүсэж байна.

Г.Тэмүүлэн: Гишүүд үг хэлж дууслаа. ЗГ-ын гишүүд сайд нар, тэр дундаа Туваан сайд сая гишүүдийн хэлсэн саналыг анхаарч үзээрэй, анхаарч үзээрэй. Сая өнөөдөр нэг талдаа энэ яаралтай горимоор Улсын Их Хурал руу 2 улсын Засгийн газар хооронд хэлэлцээр орж ирж байна. Тэгээд намрын ээлжит чуулган дууссаны дараа Эдийн засгийн байнгын хороо болоод Аюулгүй байдал, гадаад бодлогын

байнгын хороо 2 Байнгын хороо өнөөдөр хуралдаж байна. 2 Байнгын хорооны би өмнөх Байнгын хорооны хурлыг ч гэсэн үзсэн. Гишүүд маш олон саналуудыг хэлж байна. Энэ асуудлыг Засгийн газар зайлшгүй анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай шүү.

Нэг талдаа би онцолж хэлэх зүйл нь энэ ЗГ хоорондын ерөнхий хэлэлцээр байгаа ерөнхий хэлэлцээр. Бид цаана нь та бүхэн яг тэр протокол дээрээ магадгүй тэр аж ахуйн нэгж хоорондынхоо гэрээ дээрээ нарийвчилсан магадгүй санамж бичиг байна уу, ямар хуулийн хэлбэрийн бичиг баримт байна түүн дээрээ үг, үсэг болгон дээрээ алдаа гаргахгүй хариуцлагатай хандах зайлшгүй шаардлага байгаа шүү. Бид бүхний хувьд, Монгол Улсын хувьд өнөөдөр хэрэгжиж байгаа хамгийн том төсөл учраас энэ дээр бид ямар нэг алдаа гаргах эрх байхгүй гэдэг зүйлийг онцгойлон анхаарч хэлээд байгаа юм. Тэгэхээр энэ дээрээ ажил хариуцсан хүмүүс, Эрдэнэс Тавантолгой компанийнхан гэрээ хэлэлцээр дээр үг, үсэг болгон дээр нь сууж байгаа холбогдох албан тушаалтнууд хариуцлагатай хандаарай. Үг, үсэг, цэг, таслал болгон үнэ цэнтэй шүү. Энэ болгон бид бүхний хувьд дараа нь ямар нэг байдлаар алдаж болохгүй суурь асуудал.

Тэрнээс Улсын Их Хурал зөвхөн ерөнхий хэлэлцээр бол орж ирж байна. Харин та бүхэн магадгүй та бүхний хэлсэн цаг хугацааны юугаар сарын дараа магадгүй сар шинээс өмнө Улсын Их Хурлаар соёрхон батлах энэ Засгийн газар хоорондын хэлэлцээр орж ирнэ гэж харж байгаа. Энэ дээрээ үг, үсэг болгон дээр нь саяын тэр хэлж байгаа гишүүдийн хэлж байгаа санал болгоныг анхаарч ажиллах зайлшгүй шаардлага гарч ирж байгаа юм. Соёрхон батлуулахаар орж ирэхдээ, эцэслэн батлахтайгаа, нөгөө талтайгаа ярилцах, засаж залруулах, нийцүүлэх хэд хэдэн асуудлыг онцолж хэллээ. Энэ талд гишүүдийн хэлж байгаа асуудал үндсэндээ 1 дүгээр суурь зарчмын асуудал бол ерөөсөө хэлэлцээрийг харилцан ашигтай байх гэдэг дээр алдаа гаргах эрх байхгүй шүү. Тэр дундаа Монголын талын эрх ашгийг хангаж ажиллах ёстой гэдэг асуудлыг тавиад байгаа. Нүүрсний борлуулалтаас хүртэх үр өгөөжийг баталгаажуулах гэдэг асуудлыг тавигдаад байгаа юм.

Би онцолж саяын хэд хэдэн зүйлийг хэлье. Гишүүдийн хэлснээс. Хэлэлцээрийн төслийг Улсын Их Хурлын 2024 оны 58 дугаар тогтоолтой нийцүүлэх гэдэг асуудлыг ярьж байна. Нийцүүлэх, үг, үсэг болоод утга агуулгын хувьд. Тогтоолын 12 дахь заалтууд дээрээс орхигдсон зүйлүүд байна гэдэг зүйлийг ярьж байгаа шүү. 12 дахь заалт дээрээс. Энэ бол саяын тэр дутуу тусгачихсан асуудлуудыг залруул гэдэг саналуудыг гишүүд хэлж байна. Говийн ус, усан хангамж, боловсруулах үйлдвэр, саяын тэр эрчим хүч, сэргээгдэх эрчим хүчний экспорт гэж бид бүхэн тогтоол дээрээ тэр 12 дугаар заалт дээр зааснаас биш, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийг экспортлох гэдэг асуудлыг яриагүй. Сэргээгдэх эрчим хүчний экспортыг бид ярьж байгаа. Цаашид Монгол Улс илүү валют олох асуудлыг ярьж байгаа болохоос биш валют үрэх асуудлыг бид яриагүй шүү дээ. Тэгэхээр энэ болгон дээр нийцүүлэх асуудлууд байна.

Сая хил дамнасан төмөр замын асуудлыг гишүүд ярьж байна. Байгаагүй зүйл, заалтыг дэмжсэн асуудлыг хөндөж тавьж байна. Магадгүй хасах шаардлага байгаа байх. Та бүхэн нөгөө талдаа ярихдаа хасах залруулах, онцолж бүр хэлж байгаа зүйл сая энэ хэлэлцээрт орж ирж байсан 3.1 дэх асуудлыг ярьж байна. Нөгөө талын ААН-ийг оролцуулах, дэмжих таатай нөхцөлийг бүрдүүлэх гэж юу гэдэг юм бид бүхэн өмнө нь огт яригдаагүй, хэлэлцээгүй, тогтоол дээр тусгагдаагүй

асуудлууд орж ирж байна гэж харж байгаа. Тэгэхээр энэ болгон саяын тэр гишүүд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр, мөн Эдийн засгийн байнгын хороон дээр Улсын Их Хурлын гишүүдийн санаа зовниж хэлсэн энэ санал болгоныг ЗГ анхаарч үзэх ёстой. Та бүхэн үг үсэг, зүйл заалт, цэг таслал болгоноор нь энийг анхаарч үз гэдэг зүйлийг хариуцлагатайгаар хэлэх гэж байгаа юм.

Бид өнөөдөр зөвхөн юу гэдэг юм ерөнхий хэлэлцээрийг, хэлэлцээрийн төслийг зөвшилцөхөөр орж ирж байгаа зүйл дээр 2 Байнгын хорооны 30 гаруй гишүүдээр хэлэлцүүлэхэд л энэ анхаарах асуудлууд орж ирж байна. Дараагийн удаа хэрэв энэ дэмжигдсэн тохиолдолд та бүхэн соёрхон батлуулахаар нөгөө талтайгаа зөвшилцөөд ингээд орж ирэх юм бол Улсын Их Хурлаар орно. Холбогдох Байнгын хороодоор орно. 126 гишүүд энэ асуудлуудыг шүүж, батлуулах, соёрхон батлуулах эсэх дээр зөвшөөрөл авна. Тэгэхээр энэ дээр анхаарч ажиллах шаардлага байна. Энэ зүйлийг та бүхэнд онцгойлж анхаарч ажил гэдэг зүйлийг хэлэх гэсэн юм.

Компани ч гэсэн анхаарч ажиллах зүйлүүд байгаад байгаа юм. Засаглалтайгаа холбоотой. Бид бүхний өмнө нь гаргаж байсан Улсын Их Хурлын гаргаж байсан тогтоол шийдвэрүүдтэй холбоотойгоор засаглалтай холбоотой, тогтолцоотой холбоотой, хяналт үүрэгтэй холбоотой, компанийнхаа үр өгөөжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулж үйл ажиллагаа дээрээсээ нэгж тооныхоо олборлолт болоод боловсруулалт, олборлолт болоод борлуулалтынхаа өртгийг бууруулах асуудлууд байгаад байгаа. Энэ болгон дээр анхаарч ажиллаарай гэдэг зүйлийг хэлэх байна.

Гишүүд, би нэг зүйлийг хэлье. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар 2, 3 гишүүд нэлээн зарчмын горимын санал гаргаж хэлж, ярьж байна. Энэ өөрөө юу юм бэ гэхээр тодорхой хугацаанд хойшлуулаад, эргээд тодорхой мэдээллүүдийг авсны үндсэн дээр санал хураалт явуулах гэдэг юм уу эсвэл эргээд буцаад нөгөө талтайгаа зөвшилцөх, ярилцах гэдэг асуудлыг ингэж тавиад байгаа юм. Тэгэхээр яах вэ Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулиараа бид Дэгийн тухай хуулиараа манай Байнгын хороо илээр санал хураалтыг явуулж, олонхын саналаар дэмжсэн эсвэл юу гэдэг юм буцаах дэмжээгүй шалтгаанаа тайлбарласан санал, дүгнэлтээ Засгийн газарт хүргүүлэх үүрэгтэй байгаад байгаа юм. Хүргүүлэх үүрэгтэй байгаад байгаа юм. Тэгэхээр энэ хүрээндээ явагдаж, санал хураалтыг явуулна. Хэрэв магадгүй энэ асуудлыг түр хугацаанд хойшлуулах санал байсан бол хэлэлцэх асуудлаа батлахдаа бид энэ хөндөж болох асуудал байсан. Өнөөдөр хэлэлцээд эхэлсэн, одоо бол Байнгын хороо шийдвэрээ гаргана гэсэн үг байгаад байгаа.

Санал хураалтыг явуулъя. Гишүүд, хэдэн гишүүн байна вэ? 4, 8, 9, 10 гишүүн байна. Ирцэд бүртгэгдсэн 13 гишүүн байгаа. Ирцэд ороогүй 3 гишүүнд хэлж мэдэгдээрэй. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёоллоор санал хураалт явуулах юм байна. Яг энэ томьёоллоороо хураах юм байна.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын

ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг зөвшөөрч, гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёоллоор санал хураалт. Горимын саналаар санал гараагүй албан ёсоор. Нөгөө хэлэлцэх жагсаалтыг, хэлэлцэх асуудлыг батлахад тэнд горимын санал гаргаж болох байсан. Одоо бид хэлэлцээд эхэлсэн учраас хэлэлцсэн асуудлаараа санал хураалтыг явуулна. Гол нь энэ дэмжсэн, дэмжээгүй гэдэг л 2 хувилбараар хураахаар байгаад байгаа юм. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн байгаа. Санал хураалтыг явуулъя. Тэгээд ЗГ анхаарч ажиллаарай. Сая гишүүдийн хэлж байгаа саналыг ойлгож байгаа биз. Дараагийн удаа соёрхон батлуулахад энэнээс илүү олон гишүүд, олон Байнгын хороогоор орж, чуулганаар хэлэлцэгдэх байгаад байгаа шүү. Үг, үсэг дээрээ. Бүгд дэмжиж зөвшөөрч байна гэж Туваан сайд бол толгой дохиж байна гэж байгаа шүү тийм ээ.

Ингээд гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёоллоор санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 8 гишүүн дэмжиж, 57,1 хувиар дэмжигдлээ. Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, Байнгын хорооны тэмдэглэл болоод санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

16.22 цаг

Хэлэлцэх асуудал дууссан тул манай Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Байнгын хорооны гишүүд болоод ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА